

**БАНКААР ОЛГОГДОЖ БУЙ ЖИЖИГ, ДУНД
БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**



УЛААНБААТАР ХОТ

2017 ОН

АГУУЛГА

ОРШИЛ	5
НЭГ. ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	7
1.1 ЖДБ-ийн хууль эрхзүйн орчин, төрийн дэмжлэг	7
1.2 ЖДБ-ийн хөгжлийн өнөөгийн байдал	12
1.3 Эдийн засаг дахь ЖДБ-ийн үүрэг роль	14
ХОЁР. ЖДБ-ИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ.....	17
2.1 ЖДБ-ийн санхүүжилтийн байдал.....	17
2.2 Төслийн зээлүүд	24
ГУРАВ. ЖДБ-ийн зээлийн тулгамдаж буй асуудлууд	33
3.1 Зээлийн нөхцөлтэй холбоотой бэрхшээлүүд.....	33
3.2 Зээлийн процесстой холбоотой асуудлууд.....	36
3.3 Харилцагчаас хамааралтай асуудлууд.....	39
ДӨРӨВ. ЖДБ-ийн зээлийн цаашдын хандлага.....	42
4.1 Хууль эрхзүйн орчин.....	42
4.2 Банкуудын хүрээнд гарах өөрчлөлт	44
4.3 ЖДБ-үүдэд шийдвэрлэх асуудал.....	47
4.4 Бусад байгууллагын оролцоо	48
Дүгнэлт	51
Ашигласан материал:	53
Хавсралт.....	54
Хавсралт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	54
Хавсралт 2. Судалгааны асуулгын маягт.....	55
Хавсралт 3. Банкны удирдлагуудаас авсан ганцаарчилсан ярилцлагын чиглүүлэх асуултууд.....	60

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ЖДБ-ийн ангилал	7
Хүснэгт 2. Бүртгэлтэй ААН-ийн тоо, эдийн засгийн салбараар	13
Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо, бүсээр	14
Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн гарц, ажилчдын тоогоор (тэр.төг).....	14
Хүснэгт 5. Ажил эрхлэлт /эдийн засгийн салбараар/.....	15
Хүснэгт 6. Хувийн хэвшилд олгосон зээл (тэрбум төгрөг)	17
Хүснэгт 7. ЖДБ-ийн зээл	18
Хүснэгт 8. ЖДҮДС-ийн төслийн зээлийн нөхцөл	24
Хүснэгт 9. Сум хөгжлийн сангийн хуваарилалт	25
Хүснэгт 10. Сум хөгжүүлэх сангийн зээл мэдээлэл болон хамрагдсан салбарууд	26
Хүснэгт 11. ЖАЙКА-ийн төслийн үйл ажиллагааны үр дүн.....	27
Хүснэгт 12. Төслийн санхүүжилт.....	28
Хүснэгт 13. “Эх үүсвэртэй батлан даалт” бүтээгдэхүүний нөхцөл.....	30
Хүснэгт 15. КфВ төслийн зээлд хамрагдсан ЖДҮ-ийн тоо, авсан зээлийн хэмжээ /оролцогч банкаар/.....	31
Хүснэгт 16. Зээлийн материалын бүрэн бүтэн байдал, холбогдох судалгаа шинжилгээ хийхэд зарцуулж буй хугацаа, ажиллаж буй төв, салбараар ..	38

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ЖДБ-ийн хууль эрхзүй, бодлогын шинэчлэл	8
Зураг 2. Бүртгэлтэй ААН-ийн тоо болон Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо	12
Зураг 3. Судалгаанд хамрагдсан банкуудын ЖДБ-ийн зээл (хугацаа болон зориулалтаар)	19
Зураг 4. Банкуудын зээлийн бүтээгдэхүүнүүд.....	21
Зураг 5. ЖДБ-ийн зээлийн хүсэлтийн хэдэн хувь нь бодитойгоор хэрэгждэг вэ?.....	23
Зураг 6. ЖДҮДС-ийн үйл ажиллагааны үр дүн (ажлын байр болон салбараар)	25
Зураг 7. Батлан даалт гаргах схем	29
Зураг 8. КфВ төслийн зээлийн эргэлтийн сангийн эх үүсвэрийн хуваарилалт	31
Зураг 9. Хүүгийн түвшин	33
Зураг 10. Банкны салбарын хөрөнгө болон өр төлбөрийн бүтэц (2016)	34
Зураг 11. ЖДБ-үүдийн зээлийн материал бүрдүүлж буй хугацаа, банкаар	36
Зураг 12. Зээлийн хүсэлтийг судлахад хамгийн их цаг зарцуулдаг хүчин зүйлс	39
Зураг 13. Зээлийн бичиг баримт бүрдүүлэхэд хийж чадахгүй байгаа эсвэл ойлгохгүй байгаа зүйлс.....	40

ОРШИЛ

ЖДБ эрхлэгчдийг бодлогоор дэмжин, хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг бий болгож улмаар ядуурал, ажилгүйдлийн түвшинг бууруулах, дундаж давхаргынхны нийт хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлэх үндэс болдог. Дэлхийн улс орон бүрт ЖДБ эрхлэгчдийг татварын бодлого, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт аргуудаар дэмжин, хөгжүүлэх чиглэлд анхаарсаар ирсэн. Манай улсын хувьд ЖДБ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлээ тогтоож 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг батлан гаргаснаас хойш ЖДБ эрхлэгчдийг дэмжих чиглэлд олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Гэхдээ төр болон олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй ЖДБ эрхлэгчдийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг дүгнэх, ЖДБ-үүдийн хөгжлийн түвшин, санхүүжилтийн байдлыг үнэлэх нь чухал юм. ЖДБ эрхлэгчдийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээлийн талаар Монгол банкнаас сүүлийн 5 жил тасралтгүй түүвэр судалгаа явуулж байгаа бөгөөд уг судалгаанаар ЖДБ эрхлэгчдэд тулгардаг хамгийн гол асуудлын нэг нь санхүүжилт байсаар ирсэн. Уг судалгааг санхүүжилтийг хүртэгч ААН, бизнес эрхлэгч талаас хийдэг бол ЖДБ-ийн санхүүжилтийг олгогч банк санхүүгийн байгууллагын зүгээс асуудал ямар түвшинд байгааг тодруулсан судалгаа байдаггүй.

Энэ үүднээс АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн REACH төслийн захиалгаар банкаар олгогдож буй ЖДБ-ийн санхүүжилтийн өнөөгийн байдал, цаашдын хандлагыг тодруулах зорилгоор энэхүү судалгааг хийв. Ингэхдээ банкны зүгээс ирээдүйд ЖДБ-ийн талаар ямар бодлого, чиглэлтэйгээр ажиллах, санхүүжилтын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх гадаад, дотоод боломжууд, хууль эрх зүйн зүгээс сайжруулах асуудал, зээлийн материал бүрдүүлэлт болон зээл олгоход тулгардаг гол бэрхшээлүүд, тэдгээрийг даван туулахын тулд оролцогч талууд цаашид хэрхэн ажиллах шаардлагатай байгааг тодруулахыг зорьж ажиллаа.

ЖДБ-ийн талаар баримталдаг банкуудын бодлого, ЖДБ-д олгодог зээлийн бүтээгдэхүүнүүдийн хэрэгжилтийн үр дүн, цаашдын хандлага зэргийг судлахдаа асуулгын арга ашиглан арилжааны 12 банкны¹ ЖДБ-ийн зээлийн төвүүд, холбогдох салбарын 33 зээлийн мэргэжилтнүүдээс анкетаар судалгаа авсан. Түүнчлэн, 12 банкны зээлийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа хариуцсан удирдлагуудтай ганцаарчилсан ярилцлага хийж,

¹ Кредит банк нь ЖДБ-ийн зээл олгохгүй байгаа тул судалгаанд оролцохоос татгалзсан. Тээвэр хөгжлийн банк үйл ажиллагаа явуулаагүй тул мөн оролцоогүй.

банкны салбараас олгож буй ЖДБ-ийн зээл болон төслийн зээлүүдийн хэрэгжилт, цаашид баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар илүү нарийвчлан асууж тодруулав (Судалгаанд оролцогчдын мэдээллийг Хавсралтаас үзнэ үү).

Судалгааны үр дүнг SPSS 21 багц программ болон чанарын судалгаа нэгтгэх арга зүйгээр гаргав. Судалгааны хугацаа харьцангуй хязгаарлагдмал, оны сүүлийн улирал тул банкны ажилтнуудын ажлын ачаалал их байсан зэргээс хамаарч анкетийн судалгаанд нийт 33 ажилтан хамрагдсан нь үр дүн гаргахад бага тоо боловч ерөнхий дүр зургийг гаргахад тодорхой хувь нэмэр үзүүлсэн. Үүний зэрэгцээ ярилцлага болон баримтын шинжилгээнүүдийг хийж нөхцөл байдлыг тодруулсан. Эдгээрт банкны удирдлагуудаас авсан ганцаарчилсан ярилцлага, банкуудын ЖДБ-д олгосон зээлийн статистик мэдээлэл, Монгол банкны статистик, ЖДБ-ийн судалгаа зэрэг бусад анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж энэхүү тайланг бичсэн болно.

НЭГ. ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улс 1990 онд чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжсэний дараа эдийн засагт бүтцийн өөрчлөлтийг эрчимтэй хэрэгжүүлсний дүнд хувийн хэвшил хөгжиж эхэлсэн. Аж ахуйн нэгжүүдийн тоо ихээхэн нэмэгдсэн ба дийлэнх нь жижиг, дунд бизнес (ЖДБ) байна. Хэдийгээр ЖДБ-ийн дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) оруулах хувь нэмэр одоогоор бага байгаа боловч ЖДБ-ийг хөгжлийн шинэ түвшинд гаргаж чадвал эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болж чадах билээ. Энэ бүлэгт ЖДБ-ийн хууль эрхзүйн орчин, төрөөс үзүүлж буй дэмжлэг, энэ салбарын өнөөгийн байдал, ДНБ болон хөдөлмөрийн зах зээлд оруулж буй хувь нэмрийг нэгтгэн дүгнэв.

1.1 ЖДБ-ийн хууль эрхзүйн орчин, төрийн дэмжлэг

ЖДБ-ийн ач холбогдлыг үнэлж, уг салбарыг цогц байдлаар хөгжүүлэх үүднээс УИХ-аас 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг баталсан. 2007 оны 6 дугаар сараас эхэлж хэрэгжсэн уг хуулиар ЖДБ-ийг дараах байдлаар ангилсан.

Хүснэгт 1. ЖДБ-ийн ангилал

Салбар, ангилал	Ажилчдын тоо	Жилийн борлуулалт
Дунд		
1) Салбарууд [2), 3), 4)-өөс бусад]	199 хүртэл	1.5 тэрбум төгрөг хүртэл
2) Бөөний худалдаа	149 хүртэл	1.5 тэрбум төгрөг хүртэл
3) Жижиглэнгийн худалдаа	199 хүртэл	1.5 тэрбум төгрөг хүртэл
4) Үйлчилгээ	49 хүртэл	1 тэрбум төгрөг хүртэл
Жижиг		
5) Боловсруулах үйлдвэрлэл	19 хүртэл	250 сая хүртэл
6) Худалдаа	9 хүртэл	250 сая хүртэл
7) Үйлчилгээ	9 хүртэл	250 сая хүртэл

Эх сурвалж: Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, 2007 он


2007 оны ЖДБ-ийн хууль нь ЖДБ-ийг ажилчдын тоо, эдийн засгийн салбар болон жилийн борлуулалтад нь үндэслэн тодорхойлсон бөгөөд уг тодорхойлолтыг төрийн болон олон улсын байгууллагууд, банк санхүүгийн байгууллагууд мөрдөж ирсэн. Гэвч хууль батлагдсанаас хойш зөвхөн ДНБ гэхэд 4.8 дахин өссөн, бүртгэлтэй ААН-ийн тоо 2.5 дахин нэмэгдэж 141,502 болсон. Эдийн засаг тэлэхийн хэрээр ЖДБ-ийн хэмжээ, онцлог шинжүүд ч мөн өөрчлөгдсөн тул уг хуулийн тодорхойлолт нь өнөөгийн нөхцөлд тохирохоо больсон хэмээн шүүмжлэх нь ихэссэн². Хэдийгээр ажиллагсдын

² ЖДБ-ийн хуулийн шинэчилсэн найруулгыг олон нийтээр хэлэлцүүлж байгаа бөгөөд ирэх онд хуулийн өөрчлөлт батлагдах төлөвтэй байна.

тооны хувьд өөрчлөгдөөгүй ч жилийн борлуулалтын хэмжээ нь эдийн засгийн тэлэлт, үнийн өсөлт, төгрөгийн ханшны сулралаас хамаарч нэмэгдсэн тул хуулийн тодорхойлолт нь бодит байдалд нийцэхээ больжээ.

ЖДБ-ийн нийгэм, эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр, уул уурхайгаас хараат байдлыг бууруулж эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгцээ шаардлагын үүднээс УИХ болон Засгийн газраас ЖДБ-ийг дэмжих чиглэлээр янз бүрийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг санаачлан баталж ирсэн.

Зураг 1. ЖДБ-ийн хууль эрхзүй, бодлогын шинэчлэл



ЖДБ-ийг дэмжих зорилгоор баталсан хууль эрхзүй, бодлого, хөтөлбөрүүдийг тоймлон багцалбал дараах чиглэлүүд байна:

- Хууль эрхзүй болон бодлого
- Институцийн зохицуулалт
- Татварын хөнгөлөлтүүд
- Санхүүгийн дэмжлэг зэрэг болно.

(1) Хууль эрхзүй болон бодлого

2007 онд ЖДБ-ийн хуулийг УИХ-аас баталж, ЖДБ-ийн ангилал, тодорхойлолт, ААН-ийн бүртгэл, ЖДБ-ийн хөгжлийн чиглэлээр Засгийн газраас боловсруулах, хэрэгжүүлэх бодлогын чиглэл, цар хүрээг тодорхойлж, ЖДБ-ийг хариуцсан засгийн газрын байгууллага байгуулах, бизнес инкубаторуудыг байгуулах, мэдээллийн бааз бий болгох хэрэгтэйг хуульчлан баталсан. Энэхүү хуульд тулгуурлан Засгийн газрын зүгээс олон бодлого, хөтөлбөр, арга хэмжээг авч хэрэгжүүлж ирлээ.

2005 онд ЖДБ-ийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газраас баталж, 2009 болон 2014 онд шинэчилсэн. Уг хөтөлбөрөөр ЖДБ-ийг хөгжүүлэх хууль

эрхзүйн орчинг сайжруулах чиглэлээр дараах зорилтуудыг 2014 оны шинэчилсэн хөтөлбөрөөр дэвшүүлсэн байна.

- Хууль эрхзүйн орчныг сайжруулах
- Кластерийн хөгжлийг дэмжих
- Судалгаа, инновацийн хөгжлийг дэмжих
- ЖДБ-ийн чадавхийг дээшлүүлэх
- Санхүүгийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах
- ЖДБ-ийн зах зээлийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

2008 онд “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн бодлого”-ыг УИХ-аас баталж ЖДБ-ийн хөгжил нь эдийн засгийг төрөлжүүлэх зорилгыг тунхагласан. Уг бодлого нь I үе шат (2007-2015) болон II үе шат (2016-2021) гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжиж байна. Бодлогын 5.2.1-т зааснаар ЖДБ-ийн хөгжлийг хоёр дахь тэргүүлэх салбар байх болно гэж заасан. Энэ үүднээс тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн ба ЖДБ-т үзүүлэх техник болон санхүүгийн дэмжлэг тодорхой хэмжээгээр нэмэгдсэн, лиценз, зөвшөөрөл авах, бүртгүүлэх шат дамжлагыг бууруулсан.

2009 онд Засгийн газраас “Орон нутагт ЖДБ-ийг хөгжүүлэх гарын авлага” болон “Аж үйлдвэрийн бодлого”-ыг боловсруулсан ба эдгээрт ЖДБ-ийг хөгжүүлэх шаардлагыг тодорхойлж, нэмүү өртөг шингэсэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ хэмээн тодорхойлсон.

Түүнчлэн, Засгийн газрын 2012-2016 үйл ажиллагааны хөтөлбөрт ЖДБ-тэй холбогдсон дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Эдгээрт:

- ЖДБ-ийн хөгжилд саад болж буй төрийн хүнд суртлыг бууруулах үүднээс ЖДБ-ийн зөвлөл, бизнес инкубаторуудыг байгуулах;
- Засгийн газрын аж үйлдвэрийн бодлогыг боловсруулах;
- Зээлийн батлан даалтын сан, даатгалын тогтолцоог хөгжүүлж ЖДБ-ийн санхүүжилтийн хүртээмжийг дээшлүүлэх арга механизмуудыг бий болгосон;
- Боловсруулах үйлдвэрлэл, ялангуяа ноос, ноолуур, арьс ширийг боловсруулан олон улсын зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;
- Засгийн газрын төсөв, хөгжлийн сан, Хөгжлийн банк, доноруудын тусламж, хөнгөлөлттэй зээлийг ЖДБ-ийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд хуваарилах хэмээн тодорхойлсон.

2016 онд “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг УИХ баталсан. Энэхүү бодлогын баримт бичигт:

“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефт-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ” гэж заасан.

(2) Институцийн зохицуулалт

Монгол улсад ЖДБ-ийн бодлогыг хэрэгжүүлэх засгийн газрын гол байгууллага байхаар томъёолж ЖДБ-ийн хөгжлийн агентлагийг 2008 онд байгуулсан. Тус агентлагаас ЖДБ-ийг хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн дүрэм, журам, хөтөлбөрүүдийг боловсруулж, ЖДБ-тэй холбоотой эрхзүйн зохицуулалт, бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, зохицуулагч гол байгууллагаар ажилласан. Гэхдээ уг агентлагийг үе үеийн Засгийн газрын бодлогоос хамааруулан Хүнс, хөдөө аж ахуй, Аж үйлдвэр, Хөдөлмөрийн яам зэрэг хэд хэдэн яамны харъяанд оруулж ирсэн бөгөөд 2016 оноос Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрлэлийн Яамны харъяанд Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нэртэйгээр ажиллаж байна.

2009 онд ЖДБ-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн үүрэгтэй ажиллах ЖДБ-ийн Санг байгуулж, харин 2012 онд Сум Хөгжлийн Санг байгуулсан. Эдгээр сангийн үндсэн зорилго нь сонгогдсон тэргүүлэх салбарын ЖДБ-ийн төслүүдэд шаардлагатай санхүүжилтийг олгох явдал юм.

2012 онд УИХ хуралд ЖДБ-ийн хөгжлийн асуудлыг хариуцсан дэд хороог байгуулж ЖДБ-ийн хууль эрхзүйн таатай орчныг бий болгох чиглэлээр ажиллаж эхэлжээ.

(3) Татварын хөнгөлөлт

ЖДБ-ийн хөгжлийг дэмжих зорилгоор Засгийн газраас татварын хөнгөлөлт, урамшууллыг үзүүлж ирсэн ба ихэнхдээ НӨАТ болон гаалийн татварт хөнгөлөлтүүдийг эдлүүлсэн. Татварын ерөнхий хуулиар ЖДБ-ийн хэрэгцээнд зориулж импортолж буй тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлсөн. Үүний дүнд 2009-2011 онуудад 4,000 гаруй ЖДБ нийтдээ 15.5 тэрбум төгрөгний чөлөөлөлт эдэлжээ. Зарим жилүүдэд

Засгийн газраас хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч ЖДБ-үүдийн орлогын татварыг 50% бууруулж байсан.

(4) Санхүүгийн дэмжлэг

ЖДБ-ийн тухай хуульд суурилан Засгийн газар нь ЖДБ-тэй холбоотой дөрвөн тусгай санг байгуулжээ. Эдгээр нь ЖДБ сан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих сан болон Сум хөгжлийн сан юм. Эдгээрийн үйл ажиллагааны талаар 2.2 хэсэгт дурьдана.

Засгийн газраас ЖДБ-ийн сангаар дамжуулан 400 тэрбум төгрөгийг ЖДБ-үүдэд зээлийн зэрэгцээ бүсийн хөгжлийн зээл, орон нутгийн зээл, Сум хөгжлийн сан, Ноос, ноолуурын хөтөлбөр, Сүү хөтөлбөр болон бусад хөтөлбөрийн шугамаар ихээхэн хэмжээний санхүүжилтийг хийсэн. Мөн гадаад улсуудын засгийн газрууд, донор байгууллагуудаас ЖДБ-ийн хөгжлийг дэмжих чиглэлээр нэлээд хэмжээний санхүүжилт орж ирсэн. Тухайлбал, USAID-ийн зээлийн хөтөлбөрөөр ЖДБ-ийг дэмжих зээлийн баталгаа болгож 25 сая доллар, Европын Холбооноос ЖДБ-ийн хөгжил, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд 4 сая еврогийн хөгжлийн албан ёсны тусламж, Япон улсын Засгийн газраас ЖДБ-ийг хөгжүүлэх зорилгоор 75 тэрбум төгрөгийг олгосон.

Шигтгээ 1:

2011, 2012 оны уул уурхайн эдийн засгийн өсөлтөө дагаад мөн манай улс бонд гаргаад нэлээд ихгүй мөнгийг ЖДУ-ийг хөгжүүлэхэд зарцуулсан. Тэрэнтэй холбоотой, шинэ тоног төхөөрөмж худалдаж авах, шинэ бизнес санаа эхлүүлэх гэсэн байгууллага, хувь хүмүүс олон байсан. Санхүүжилт авсан зарим төслүүд амжилттай хэрэгжсэн. Бас тоног төхөөрөмжаа аваад бүтээгдэхүүнээ үйлдвэрлэтэл зах зээлийн нийцэлээ олоогүй, хэт өндөр өртөгтэй, зах зээлд борлуулах боломжгүй, эсвэл менежментээ өөрсдөө авч явж чадахгүй зэргээс амжилт олоогүй ЖДБ-ийн тохиолдлууд нэлээдгүй гарсан.


Худалдаа хөгжлийн банк

Засгийн газрын зүгээс ЖДБ-ийг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч дийлэнх нь хоорондоо уялдаа холбоогүй, тогтвортой биш байдлаар хэрэгжсэнээс шалтгаалж ЖДБ-д үзүүлсэн нөлөө төдийлөн сайн биш байна. Иймд өнөөдөр хэрэгжиж буй ЖДБ-тэй холбоотой хууль, дүрэм журам, бодлого, хөтөлбөрүүдийг цэгцэлж, энэ салбарын хөгжлийг цогцоор нь тусгасан цогц бодлогыг боловсруулж, оролцогч талуудыг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилт болон уялдаа холбоог хангах тодорхой механизмуудыг дэвшүүлэх шаардлагатай.

1.2 ЖДБ-ийн хөгжлийн өнөөгийн байдал

Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 2000 оноос хойш байнга өсч ирсэн. Сүүлийн 17 жилийн хугацаанд бүртгэлтэй ААН нь тооны хувьд 6.6 дахин нэмэгдсэн. Харин эдгээрийн тал нь буюу 51% нь л үйл ажиллагаа эрхэлдэг, 17% нь ажиллаж эхлээгүй, 29% нь үйл ажиллагаагаа түр зогсоосон, 3% нь бүртгүүлсэн газараа байгаагүй байна. Мөн дийлэнх ААН нь 1-9 ажилчинтай жижиг ААН-үүд байдаг ба эдгээрийн тоо нь өнгөрсөн хугацаанд 4 дахин нэмэгджээ.

Зураг 2. Бүртгэлтэй ААН-ийн тоо болон Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх зургаас харахад үйл ажиллагаа явуулж буй ЖДБ (50 хүртэлх ажилчинтай) нь нийт хувийн хэвшлийн ААН-ийн 97 хувийг бүрдүүлж байна. Дийлэнх ЖДБ нь дөнгөж үйл ажиллагаа явуулж буй гарааны бизнес болон 10 хүртэлх ажилчинтай жижиг ААН-үүд байна.

Шигтгээ 2:

Банк ЖДБ эрхлэгчдийн дунд судалгаа хийхэд үзэхэд ЖДБ эрхлэгчдийн тоо харьцангуй өссөн, ялангуяа шинэ техник технологи нэвтрүүлсэн, нийгэмд хэрэгтэй зүйл хийе, ажлын байр нэмэгдүүлье гэсэн санаачилгаар бизнес эрхлэгчдийн тоо өссөн сайшаалтай байгаа.

Капитрон банк

Салбарын тархалтыг авч үзвэл ЖДБ-ийн 70 гаруй хувь нь худалдаа болон бусад үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг. 2000 оноос хойш эдийн засгийн салбаруудад зарим нэг бүтцийн өөрчлөлт ажиглагджээ. ХАА, боловсруулах үйлдвэрлэл, төрийн удирдлага, эрүүл мэнд, боловсролын салбарын ААН-үүдийн тоо аажмаар буурч, харин барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйлчилгээний салбар дахь ААН-ийн тоо өсчээ.

Хүснэгт 2. Бүртгэлтэй ААН-ийн тоо, эдийн засгийн салбараар

Эдийн засгийн салбарууд	2000		2005			2010			2015			2016		
	Тоо	%	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт	1,813	8%	2,208	6%	13%	3,183	4%	8%	6,661	5%	5%	7,078	5%	6%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	217	1%	373	1%	26%	795	1%	10%	1,155	1%	22%	1,259	1%	9%
Боловсруулах үйлдвэр	2,909	13%	3,087	8%	14%	4,912	7%	9%	9,934	8%	8%	10,406	7%	5%
Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	215	1%	236	1%	7%	267	0.4%	-5%	344	0.3%	-10%	346	0%	1%
Барилга	616	3%	1,154	3%	25%	3,057	4%	17%	10,496	8%	17%	11,430	8%	9%
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	7,635	34%	17,122	43%	19%	36,297	49%	24%	54,303	43%	11%	60,171	43%	11%
Зочид буудал, зоогийн газар	839	4%	1,427	4%	35%	2,228	3%	3%	3,349	3%	3%	3,632	3%	8%
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	686	3%	996	3%	38%	2,344	3%	9%	5,529	4%	9%	6,217	4%	12%
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	231	1%	1,217	3%	36%	1,208	2%	1%	1,920	2%	-7%	1,946	1%	1%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	930	4%	2,403	6%	48%	5,030	7%	12%	12,656	10%	9%	14,183	10%	12%
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	1,250	6%	1,357	3%	-0.1%	1,605	2%	1%	1,434	1%	0.1%	1,435	1%	0%
Боловсролын салбарын үйл ажиллагаа	1,577	7%	1,972	5%	9%	2,528	3%	6%	4,209	3%	17%	4,844	3%	15%
Эруул мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1,370	6%	1,994	5%	6%	2,678	4%	2%	3,831	3%	10%	4,071	3%	6%
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	2,433	11%	4,129	10%	-6%	7,654	10%	2%	10,715	8%	28%	14,460	10%	35%
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	3	0.01%	2	0.01%	-33%	9	0.01%	50%	24	0.02%	-4%	24	0%	0%
Нийт ААН-ийн тоо	22,724	100%	39,677	100%	16%	73,795	100%	14%	126,560	100%	11%	141,502	100%	12%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт салбарт эзлэх хувийн жин болон өсөлтийн хувьд бөөний болон жижиглэнгийн худалдаа хамгийн их буюу 43%-ийг, харин үл хөдлөх хөрөнгийн бизнес (10%) болон барилгын салбар (8%) удаалжээ. Хөдөө аж ахуйн улс гэдэг манай орны нийт салбарт эзлэх ХАА-н бизнесүүдийн тоо ердөө 5% байгаа нь малчид, тариаланчид хувь хүн, өрхөөрөө аж ахуйн эрхэлдэг тул ААН болж бүртгүүлдэггүйтэй холбоотой. Түүнчлэн, газрын доорх ашигт малтмалын нөөцөөр баялаг боловч уул уурхайн бүртгэлтэй ААН-ын тоо 2016 онд дөнгөж 1,259 буюу 1% байсан. Энэ нь хөдөлмөрлөх хүч бага, харин хөрөнгө оруулалт их шаарддаг уул уурхайн салбарын онцлогтой ч холбоотой. Нөгөө талаас стратегийн томоохон ордуудад гадаадын компаниуд ихэвчлэн үйл ажиллагаа явуулдаг тул Монголд бүртгүүлдэггүйтэй холбоотой.

Төрөөс эдийн засгийг төрөлжүүлэх, боловсруулах үйлдвэрлэл, барилгыг дэмжих чиглэлийн бодлого, хөтөлбөр баримталсаны дүнд боловсруулах үйлдвэрлэлийн ААН-ийн тоо 4 дахин, барилгын компаниуд 18 дахин нэмэгдсэн. Гэхдээ өнгөрсөн хугацаанд боловсруулах үйлдвэрлэлийн нийт ААН-д эзлэх хувийн жин 6 пунктээр буурч 7 хувийг л эзлэх болсон. Энэ бууралт нь дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийг орлох зүйлсийг гаднаас импортолдог худалдааны компаниуд олширсон, нөгөө талаас бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг импортын түүхий эдийн үнэ нь ханшийн нөлөөнөөс хамаарч өссөнтэй тодорхой хэмжээгээр холбоотой юм. Гэсэн хэдий ч Засгийн газрын зүгээс нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл болон шинээр ажлын байр бий болгох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж

ирсэн нь боловсруулах үйлдвэрлэлийг хэт унагачихгүй, харин ч жилд дунджаар 8 хувийн өсөлттэй гарахад түлхэц болсон. Салбарын бүтцээс харахад үйлдвэрлэл бус худалдаа, үйлчилгээний салбар хэт ноёлж байгаа нь нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүнтэй байж, валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх гэсэн Засгийн газрын бодлого бүрэн хэрэгжээгүйг харуулж байгаа тул цаашид эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулах чиглэлээр тодорхой үр дүнтэй алхмуудыг хийх шаардлагатай.

ЖДБ-ийн газарзүйн байршлын хувьд дараах хүснэгтэнд харуулсны дагуу нийт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн 64% нь нийслэл хотод байрладаг, Төвийн бүс болон гол боомтуудад ААН-үүдийн 12%, Хангайн болон Баруун бүсэд нийлээд 20% нь байршдаг.

Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо, бүсээр

Бүс	2010		2011		2014		2015		2016	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улаанбаатар	26,852	66%	30,866	64%	37,124	62%	40,381	63%	46,153	64%
Төвийн бүс	4,832	12%	5,951	12%	7,496	13%	7,862	12%	8,499	12%
Хангайн бүс	4,175	10%	5,186	11%	6,787	11%	7,113	11%	7,924	11%
Баруун бүс	3,393	8%	4,120	9%	5,770	10%	6,119	10%	6,485	9%
Зүүн бүс	1,669	4%	1,963	4%	2,666	4%	2,826	4%	3,121	4%
Нийт	40,921	100%	48,086	100%	59,843	100%	64,301	100%	72,182	100%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэхүү бүтэц нь сүүлийн 16 жилд бараг өөрчлөгдөхгүй хадгалагдсан нь 2005 оноос хойш төр засгаас санаачлан хэрэгжүүлсэн бүсчилсэн хөгжлийн бодлого, арга хэмжээнүүд үр дүн тааруу байгааг харуулж байна.

1.3 Эдийн засаг дахь ЖДБ-ийн үүрэг роль

Манай улсын эдийн засаг нь хувийн хэвшлээс ихээхэн хамааралтай. Үндэсний Статистикийн Хорооны тайлангаар хувийн хэвшлийн ДНБ дэх оролцоо нь 1996 онд 57%, 2007 онд 68.4%, 2012 онд 75% байсан³.

Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн гарц, ажилчдын тоогоор (тэр.төг)

Хэмжээ /ажилчдын тоо/	2009			2010			2011			2012*		
	Гарц	Эзлэх хувь	Өсөлт	Гарц	Эзлэх хувь	Өсөлт	Гарц	Эзлэх хувь	Өсөлт	Гарц	Эзлэх хувь	Өсөлт
1-9	267.8	10.3%		382.5	10.1%	42.8%	516.2	10.1%	35.0%	599.3	10.2%	16.1%
10-29	81.2	2.4%		117.8	2.4%	45.1%	159.0	2.4%	35.0%	183.7	2.4%	15.5%
30-49	250.2	7.3%		363.7	7.3%	45.3%	490.9	7.3%	35.0%	566.6	7.3%	15.4%
Нийт (1-49)	599.2	20.0%		864.1	19.8%	44.2%	1,166.1	17.3%	34.9%	1,349.6	19.9%	15.7%
50-аас дээш	2,842.7	80.0%		4,122.9	80.2%	45.0%	5,563.7	82.7%	34.4%	6,427.1	80.2%	15.5%
Нийт	3,441.9	100.0%		4,987.0	100%	44.9%	6,729.8	100%	34.9%	7,776.7	100%	15.6%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

³ 2012 оноос хойших ажилчдын тооны ангиллаарх хувийн хэвшлийн гарцын мэдээлэл олдоогүй.

Үйлдвэрлэлийн гарцаас харахад 50-аас дээш ажилчинтай дунд болон том ААН-үүд нь нийт үйлдвэрлэлийн 80 хувийг гаргадаг, харин үлдсэн 20 хувийг 1-50 хүртэлх ажилчинтай жижиг ААН-үүд үйлдвэрлэдэг байна. Үүн дотор нийт ААН дотор 85 хувийг эзэлдэг 1-9 ажилчинтай жижиг ААН-үүд нь дөнгөж 10 хувийг л үйлдвэрлэж байгаа нь эдийн засагт жижиг ААН-үүдийн оролцоо бага, тархай бутархай олон хэсэгт хуваагдан хүч тарамдсан байдалтай байгааг илтгэнэ.

Хөдөлмөрийн зах зээл талаас нь үзвэл хувийн хэвшлийн гол тулгуур болохынхоо хувьд ЖДБ нь хамгийн их ажил эрхлэлтийг бий болгодог тул төрийн зүгээс ажил эрхлэлтийг дэмжих бодлого нь ЖДБ-ийг хөгжүүлэх бодлоготой зэрэгцэн хэрэгждэг.

Хүснэгт 5. Ажил эрхлэлт /эдийн засгийн салбараар/

Эдийн засгийн салбарууд	2010			2012			2014			2015			2016		
	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт	Тоо	%	Өсөлт
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аа	346,579	34%	-1%	369,961	35%	8%	310,719	28%	-6%	327,600	28%	5%	348,400	30%	6%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	34,115	3%	-2%	46,696	4%	4%	40,927	4%	-19%	42,600	4%	4%	38,200	3%	-10%
Боловсруулах үйлдвэр	64,776	6%	3%	64,895	6%	-1%	85,497	8%	6%	81,300	7%	-5%	86,100	8%	6%
Цахилгаан хий үйлдвэрлэл	12,397	1%	30%	14,495	1%	21%	15,454	1%	12%	15,600	1%	1%	16,200	1%	4%
Ус хангамж, бусад	7,791	1%	28%	6,679	1%	30%	7,140	1%	-10%	5,900	1%	-17%	6,000	1%	2%
Барилга	48,758	5%	-2%	59,204	6%	14%	81,127	7%	12%	88,100	8%	9%	71,400	6%	-19%
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	146,164	14%	-9%	131,341	12%	-14%	170,234	15%	9%	178,200	15%	5%	172,700	15%	-3%
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	76,533	7%	11%	56,092	5%	-26%	69,815	6%	6%	72,700	6%	4%	65,900	6%	-9%
Зочид буудал, зоогийн газар	27,734	3%	19%	30,235	3%	15%	36,552	3%	15%	37,800	3%	3%	32,100	3%	-15%
Мэдээлэл, харилцаа холбоо	14,496	1%	43%	14,741	1%	28%	17,796	2%	6%	16,000	1%	-10%	18,100	2%	13%
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	15,163	1%	24%	17,373	2%	5%	22,914	2%	10%	23,800	2%	4%	21,900	2%	-8%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	474	0%	113%	1,208	0%	275%	1,081	0%	40%	1,000	0%	-7%	800	0%	-20%
Мэргэжлийн болон ШУ, техникийн ажиллагаа	9,576	1%	-12%	11,342	1%	-1%	12,527	1%	-8%	14,100	1%	13%	12,700	1%	-10%
хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл	70,427	7%	696%	76,254	7%	728%	78,153	7%	420%	84,100	7%	8%	89,200	8%	6%
Боловсролын салбарын үйл ажил	85,293	8%	14%	86,271	8%	1%	89,552	8%	0%	89,000	8%	-1%	95,000	8%	7%
Эрүүл мэнд, нийгмийн халамж, бусад	40,326	4%	13%	37,528	4%	3%	37,487	3%	-7%	38,200	3%	2%	41,000	4%	7%
Бусад	24601	2%	123%	32126	3%	-5%	33723	3%	2%	35,200	3%	4%	32,100	3%	-9%
Нийт ААН-ийн тоо	1,025,203	100%	10%	1,056,441	100%	8%	1,110,698	100%	7%	1,151,200	100%	4%	1,147,800	100%	-0.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2000 оноос хойш нийт ажиллагсдын 1/3 нь ХАА салбарт ажилласаар ирсэн. Эдгээрийн дийлэнх нь малчид, тариаланчид бөгөөд өөрсдийн олсон ХАА-н орлогоороо амьжиргаагаа залгуулдаг. Салбарын бүтцэд голлох байр суурь эзлэх болсон бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 2016 оны байдлаар 172,700 хүн (15%) ажиллаж байв. Уг салбарын ажилчдын өсөлт 2012 онд буурсан нь худалдаа эрхлэгчдийн тодорхой хувь нь илүү их ашигтай ажиллах гэсэн төсөөлөлтэйгөөр боловсруулах үйлдвэрлэлийн салбар руу шилжсэн, импортын бараа, материалын үнэ нэмэгдэж дотоодод арилжихад хүндрэлтэй болсон, Засгийн газраас импортыг бууруулах

бодлого явуулсан зэрэгтэй холбоотой юм. Гэхдээ эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан боловсруулах үйлдвэрлэл уналттай байсны улмаас энэ хандлага өөрчлөгдөж худалдааны салбарт ажиллагсад эргээд нэмэгдсэн. Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын бизнес нь хамгийн их өсөлттэй салбар бөгөөд 2010 онд 113%, 2011 онд 275% байсан. Эдийн засгийн уналттай байсан 2014 онд ч энэ салбар 40 хувийн өсөлтийг үзүүлсэн. Эдийн засгийн салбарын бүтцийн нэгэн адил салбарын ажил эрхлэлтийн бүтцээс харахад манай улсын эдийн засагт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дутмаг, ажиллагсдын дийлэнх нь ХАА болон үйлчилгээний салбарт ажиллаж байна.

ХОЁР. ЖДБ-ИЙН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ

2.1 ЖДБ-ийн санхүүжилтийн байдал

Өнгөрсөн хугацаанд эдийн засгийн тэлэлт, банкуудын хөрөнгө нэмэгдсэн, хувийн хэвшлийн ААН-үүдийн санхүүгийн чадавхи сайжирсантай холбоотойгоор ААН-үүдэд олгосон зээлийн хэмжээ өссөн. 2010 онд 2.8 их наяд төгрөгийн зээлийг хувийн хэвшилд олгож байсан бол 6 жилийн дотор уг үзүүлэлт 10.4 их наяд болж 3 дахин нэмэгджээ. 2016 оны эцсийн байдлаар 1-5 жилийн буюу дунд хугацааны зээл нь нийт олгосон зээлийн 58%, урт хугацаат зээл 23 хувийг эзэлж байв.

Хүснэгт 6. Хувийн хэвшилд олгосон зээл (тэрбум төгрөг)

Зээл	Нийт		ХАА		Уул уурхай		Боловсруулах		Барилга		Үйлчилгээ, бусад	
	2010	2016	2010	2016	2010	2016	2010	2016	2010	2016	2010	2016
Хэвийн зээл	2,769.9	10,390.0	101.8	254.5	301.1	166.6	355.7	1,061.0	297.1	1,201.5	1,714.2	7,706.4
1 жил хүртэлх	737.8	1,999.0	36.0	72.1	84.0	28.5	113.2	146.1	77.7	110.9	426.9	1,641.4
1-5 жил	1,569.7	5,980.0	57.5	154.1	216.1	138.0	211.0	831.5	195.4	1,046.0	889.7	3,810.4
5-аас дээш жил	462.2	2,411.5	8.3	28.4	0.9	0.1	31.5	83.4	24.0	44.7	397.5	2,254.9

Эх сурвалж: Монгол Банк, Зээлийн тайлангууд (2010 болон 2016)

Харин 1 жил хүртэлх богино хугацаат зээл нь нийт олгосон зээлийн 19 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 16 жилд гарсан томоохон өөрчлөлтийг илтгэнэ. 2000-аад оны эхээр нийт зээлийн багцийн бараг 90% нь богино хугацаат зээл байв. Хэдийгээр 5-аас дээш жилийн урт хугацаат зээл 2010 онтой харьцуулахад 6 пунктээр өссөн ч нийт дүнд эзлэх хувь нь ¼-ээс бага хэвээр л байна. Энэ нь банкны салбарт урт хугацаат эх үүсвэр хангалтгүй байгааг харуулж байна. Ерөнхий хандлагыг харвал санхүүгийн хүртээмж сайжирсан бөгөөд энэ нь Засгийн газраас явуулж буй дэмжлэг, хөтөлбөрүүд, арилжааны банкуудын гаднаас татаж буй эх үүсвэр нэмэгдсэн, донор байгууллагуудаас хэрэгжүүлж буй урт хугацааны санхүүжилтийн төслүүд, хөнгөлөлттэй зээлтэй холбоотой билээ.


Олгосон зээлийн салбарын бүтцийг харвал уул уурхайн салбарт олгосон зээл 2 дахин буурч, харин ХАА-н салбарын зээл 2.5, боловсруулах салбарынх 3 дахин, барилын салбарынх 4 дахин, үйлчилгээний салбарт олгосон зээл 4.5 дахин нэмэгджээ. Ялангуяа, боловсруулах болон барилгын салбарын зээлийн өсөлтөд Засгийн газар, Монгол банкны зүгээс хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд, ялангуяа үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлүүд ихээхэн нөлөөлсөн. Харин хамгийн их өсөлттэй байсан үйлчилгээний салбарын зээлийн өсөлт нь манай улсын эдийн засаг үйлчилгээний салбараас, түүн дотроо худалдааны салбараас ихээхэн хамааралтай болж байгааг илтгэнэ. Банкуудын удирдлагатай хийсэн

ярилцлагын үеээр худалдааны салбарын эргэлт нь бусад салбараас илүү хурдан тул банкуудын олгож буй зээлийн дийлэнх хувийг зээлээ хугацаанд нь эргүүлэн төлөх чадвэртэй худалдаа эрхлэгчид авдаг гэдгийг хэлсэн.

Хэдийгээр олгосон зээлийн хэмжээ 3 дахин нэмэгдсэн ч ЖДБ-ийн хөгжил, санхүүжилтийн талаар 2011 оноос хойш тогтмол хийгдэж буй Монгол Банкны судалгаанаас харахад Санхүүжилтийн орчин нь Нийгэм улс төрийн орчин зэргийн дараа дөрөвдүгээр хүндрэлтэй орчноор тогтмол нэрлэгдэж ирсэн. Санхүүжилтийн орчин гэдэгт зээлийн хүү, шимтгэл хураамж, барьцаа хөрөнгө, зээлийн хэмжээ, хугацаа болон зээлийн батлан даалтыг хамааруулж байгаа ба энэхүү орчин нь бизнес эрхлэгчдэд ихээхэн хүндрэл учруулдаг хэмээн жил бүр дурьдсаар ирсэн. Эдгээр асуудлыг дараагийн хэсэгт тодорхой дурьдах болно.

ЖДБ-ийн санхүүгийн хүртээмжийн нэг гол үзүүлэлт бол ЖДБ-д олгосон зээлийн хэмжээ билээ. Хэдийгээр нийт зээлийн хэмжээ 3 дахин нэмэгдсэн ч ЖДБ-д олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин доогуур хэвээрээ л байна. 2008 болон 2010 онд 20 хувьд ойртож байснаа эдийн засгийн хямралтай холбоотойгоор буурч 18 орчим хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. ЖДБ-ийн зээл




Эх сурвалж: Монгол Банк "ЖДБ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал - 2016"

Эндээс харахад хувийн хэвшлийн ААН-үүдийн дийлэнхийг бүрдүүлдэг ч ЖДБ-д олгодог зээл нь нийт зээлийн багцын 1/5 хувьд ч хүрэхгүй байна.

Судалгаанд хамрагдсан 12 банкны 2016 оны статистик мэдээллээс харахад ЖДБ-ийн зээлийн 61% нь ЖДБ-үүдэд, 39% нь бизнес эрхлэгчдэд олгосон ба ЖДБ-ийн зээл нь нийт зээлийн багцын 15 хувийг дунджаар эзэлж байна. Олгосон зээлийн хугацаа болон зориулалтыг дараах зурганд тоймлон харуулав.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан банкуудын ЖДБ-ийн зээл (хугацаа болон зориулалтаар)



ЖДБ-ийн зээлийн дийлэнх нь 1-5 жил хүртэлх хугацаатай⁴, 18% нь 5 жилээс дээш хугацаатай хөрөнгө оруулалтын зээл байна. Нийт олгосон ЖДБ-ийн зээлийн 36% нь төслийн зээл, үлдсэн 64% нь банкны өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна. Энд төслийн зээлүүдээс банкны урт хугацаат зээл ерөнхийдөө бүрдэж байгаа бөгөөд энэ төрлийн зээлийн эрэлт их байдаг. Зээлийн зориулалтыг судлахад эргэлтийн хөрөнгийн зээл дангаараа хамгийн их хувийг буюу 38 хувийг эзэлдэг, тоног төхөөрөмж болон үл хөдлөх хөрөнгийн зээл нийлээд нийт зээлийн 1/5 хувийг, харин бусад ангилагдаагүй зээлүүд нийлээд 39 хувийг эзэлж байна. Байршлаар нь авч үзвэл ЖДБ-ийн нийт зээлийн 72.5 хувийг Улаанбаатар хотын ЖДБ-үүдэд, 27.5 хувийг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ЖДБ-үүдэд олгожээ.

ЖДБ-ийн зээлийн дүн харьцангуй бага буюу 18% байгаа нь банкны зүгээс энэ төрлийн зээлийг олгох сонирхол бага байна уу, зээлийн бодлого нь ЖДБ-ийг дэмжих чиглэлд байна уу гэдгийг банкуудын удирдах ажилтнуудаас тодруулсан. Учир нь 2000-аад онд банкууд ЖДБ-ийг эрсдэл өндөртэй, ийм төрлийн зээлийг судлахад цаг зарцуулалт болон өртөг өндөртэй тул цөөн зээлийг томоохон компаниудад өгөх бодлоготой байсан. Энэ бодлого одоо ч хүчинтэй байгаа эсэхийг асуухад судалгаанд хамрагдсан 12 банкны удирдлагууд өнөөгийн түвшинд банкууд харин ч ЖДБ-ийн зээлийг олгох сонирхолтой болсон гэдгийг илэрхийлсэн.

⁴ Ихэнх банкны эргэлтийн хөрөнгийн зээл нь 2 жил хүртэлх хугацаатай байгаа нь энэ дүнд багтсан

Томоохон корпорациудтай илүү хамтран ажилладаг, тэдэнд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгодог байсан банкны хувьд ч мөн адил ЖДБ-ийг дэмжих бодлогыг баримталж байна.

Шигтгээ 3:

Манай банк Corporate чиглэлийн банк байсан учраас илүү том зээлүүд дээр төвлөрч буюу нийт зээлийн 80%-ийг олгодог банк байсан. 2011 оноос хойш Retail, SME зах зээлээ тэлье гэсэн бодлого барьж ажилласан. Мөн орон нутагт салбарын тоогоо нэмсэн, төсөл хөтөлбөрүүдтэй маш сайн уялдаа холбоотой ажилласан. Үүний дүнд манай банкны нийт зээлийн багцийн 36 хувийг ЖДБ болон иргэдийн зах зээлийн зээл эзэлчихээд байна.

Худалдаа хөгжлийн банк

Ингэж өөрчлөгдсөн гол шалтгаан нь 2009 оны хямрал болон уул уурхайн өсөлтийн дараачаар залгасан эдийн засгийн хямралын жилүүдэд томоохон зээлдэгчдийн зээлийн төлбөр удааширч, зарим нь дампуурснаас шалтгаалж банкуудын зээлийн багцын эрсдэл ихээхэн нэмэгдэж, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн. Иймээс жижиг, ажиллагаа ихтэй ч гэсэн ЖДБ-т зээл олгох нь зээлийн багцын эрсдлийг тархаан байршуулахад чухал ач холбогдолтой болохыг банкууд ойлгосон.

Шигтгээ 4:

Манай банкны хувьд том байгууллагууд болон ЖДБ ба иргэдийн зээлийг 50:50 харьцаатай байлгах бодлогыг эртнээс баримталж байгаа. Энэ нь нэг талаас зээлийн төвлөрлийг бууруулах, эрсдлээ хуваах давуу талтай юм.

Голомт банк

Түүнчлэн, улсын хэмжээнд нийт бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн ААН-ийн 97 хувийг ЖДБ-үүд бүрдүүлж байгаа тул тоон талаасаа харсан ч цөөн томоохон ААН-үүдийг хэдэн том банкууд нэгэнт харилцагчаараа авч зээл олгосон тул бусад банкуудын хувьд ЖДБ-үүдэд анхаарал хандуулахаас өөр аргагүй юм.

Шигтгээ 5:

Хэдийгээр ЖДБ-ийн зээл өндөр зардалтай ч манай банк зээл олгох бодлого баримталж байгаа. Мөн олон ЖДБ-т зээл олгох болохоор тооны хувьд ч хүртээмжтэй, эрсдэл нь тархаад, барьцаа хөрөнгийн хүрэлцээ нь ч хангалттай гээд олон зүйлийг бодоод жижиг дунд зээл олгоно гэсэн бодлоготой байгаа.


Богд банк

ЖДБ эрхлэгчдэд олгох зээлийг чухалчилахдаа ногоон эдийн засаг, байгаль орчинд ээлтэй, импортын бүтээгдэхүүнийг орлох, экспортод чиглэсэн,

инновацийг дэмжсэн төсөл, бизнесүүдийг дэмжих хандлагатай байна. Мөн эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн бизнесийн зээл олгохдоо салбар болон зээлийн хэмжээг түлхүү анхаардаг болжээ. Энэ чиглэлээр банкууд өөрсдийн судалгаануудыг хийж, эдийн засгийн цаашдын хандлага, өсөлттэй байх салбаруудыг тодруулах, үүнд үндэслэн зээлийн багцаа хуваарилах зэргээр өмнө үеэ бодвол илүү судалгаанд суурилсан шийдвэрүүдийг гаргах хандлагатай болсон нь ажиглагдана. Ялангуяа, томоохон тоглогчид болох ХААН, ХХБ, Голомт, Хас банкууд энэ чиглэлд манлайлж байна.

ЖДБ-ийн үйл ажиллагаанд тохирсон зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгох, ялангуяа хүү бага, хугацаа урттай төслийн зээлүүдийг олгох талаар банкууд ихээхэн чармайлт гаргаж байна. Дараах зурагт банкуудын зээлийн бүтээгдэхүүнийг нэгтгэн харуулав.

Зураг 4. Банкуудын зээлийн бүтээгдэхүүнүүд⁵



Банкуудын хувьд зээлийн эх үүсвэртээ тохируулан ЖДБ эрхлэгчдэд тохирох бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж байна. Тухайлбал, уламжлалт зээлийн бүтээгдэхүүнүүдээс гадна гэрээнд суурилсан зээл, Start-up бизнесийг дэмжсэн, гадны банкуудтай хамтарсан санхүүжилт бүхий зээл зэрэг төрөл бүрийн хайбрид бүтээгдэхүүнүүдийг банкууд шинээр нэвтрүүлж эхэлсэн. Энэ нь банкууд өөрсдийн хандлагыг шинэчилж, хүүгээр бус

⁵ Төслийн эх үүсвэрээр олгодог зээлүүдийг 2.2 хэсэгт дэлгэрэнгүй тунилцуулав.

инновацилаг, харилцагчдынхаа нөхцөл байдалд нийцсэн бүтээгдэхүүнээр өрсөлдөх хандлагатай болсныг илтгэнэ. Хэдий тийм боловч банкны эх үүсвэрийн (хадгаламж) хугацаа богино, хүү өндөр тул зээлийн бүтээгдэхүүний хугацаа богино, хүү өндөр байдаг. Харин төслийн зээлүүдийн хувьд банкны зээлийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад урт хугацаатай, хүү багатай тул эдгээрийн зээлийн эрэлт өндөр байдаг. Гэхдээ ирүүлсэн хүсэлтүүдийн нэлээд нь төслийн зээлүүдээс тавьдаг шаардлагыг хангадаггүй.

Анкетийн асуулгын хүрээнд банкууд өөрсдийн зээлийн бүтээгдэхүүний эрэлтийг хэрхэн үнэлж, өөрчлөх шаардлагатай эсэхийг мэдэрдэг болохыг тодруулах асуултууд тавихад зээлийн мэргэжилтнүүд дараах хариултуудыг өгсөн.

Зээлийн бүтээгдэхүүн нь ЖДБ-ийн эрэлт хэрэгцээнд нийцдэг үү хэмээн асуухад судалгаанд оролцсон зээлийн мэргэжилтнүүдийн 55% нь нийцдэг, харин үлдсэн 45% нь сайжруулах шаардлагатай хэмээн дүгнэсэн. Ингэж сайжруулахдаа:

- ✓ Бизнесийн онцлогт тохирсон хүү багатай, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн
- ✓ Хүнд даацын машин, тусгай зориулалтын машин механизм, тоног төхөөрөмжийн зээлийн бүтээгдэхүүн
- ✓ Гарааны бизнесүүдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүн
- ✓ Орлого барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг тус тус хөгжүүлэх шаардлагатай гэж хариулжээ.

Эндээс ЖДБ-тэй тулж ажилладаг мэргэжилтнүүдийн хувьд ч гэсэн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад ээлтэй байдлаар өөрчлөх шаардлагатай байгааг тодорхой хэмжээгээр ухамсарлаж, илүү шинэлэг бүтээгдэхүүнүүд болох төслийн санхүүжилт, гарааны бизнесийн санхүүжилтэд анхаарах хэрэгтэй болсныг мэдэрсэн нь ажиглагдаж байна.

Зээлийн эрэлттэй холбоотой бас нэг асуулт нь ирсэн зээлийн хүсэлтүүдийн хэдэн хувь нь бодитойгоор зээл болон олгогддог талаар байв. Судалгаанд оролцогсдын хариулснаар нийт ирсэн зээлийн хүсэлтийн тал орчим хувь нь ЖДБ-ийн зээл авах хүсэлт байдаг байна. Гэхдээ зээл олгох эх үүсвэр хангалттай эсэхээс хамаарч зарим банкуудад илүү их ЖДБ-ийн зээлийн хүсэлт ирдэг бол жижгэвтэр банкинд ЖДБ-ийн хүсэлт харьцангуй цөөн ирдэг. Томоохон банкууд болох Хас банк, Капитрон банк, Голомт банк, ХХБ-ны зээлийн төвүүдэд ЖДБ-ийн зээлийн хүсэлт харьцангуй их ирдэг байна.

Шигтгээ 6:

Манай банкны хувьд сүүлийн 2-3 жилийн хугацаанд зээлийн эх үүсвэрийн хугацаа богино, төслийн эх үүсвэр өсөөгүй байгаатай холбоотойгоор ЖДБ эрхлэгчдийн эрэлтэд нийцсэн зээлийг өгч чадахгүй байна. Жишээлбэл, ЖАЙКА-ийн зээлийн эх үүсвэр нэмэгдээгүй эргэн төлөлтөөсөө санхүүжигдэж байгаа. Банкинд ирж байгаа хүсэлтийн 20 орчим хувь нь идэвхтэй явж байгаа 1, 2 төслийн эх үүсвэрээр санхүүжигддэг.

УБ хотын банк

Ирүүлсэн зээлийн хүсэлтийн хэд орчим хувьд нь бодитойгоор зээл болон олгогддог вэ? хэмээн судалгаанд оролцогчдоос тодруулахад дунджаар 64 хувьд нь зээл олгодог хэмээн хариулсан.

Зураг 5. ЖДБ-ийн зээлийн хүсэлтийн хэдэн хувь нь бодитойгоор хэрэгждэг вэ?



Капитал, Голомт, ХХБ зэрэг зарим банкуудын хувьд ирсэн хүсэлтийн 70-80 орчим хувь нь бодитойгоор зээл болон олгогддог гэсэн нь тэдгээр банкны зээлийн мэргэжилтнүүд зээлийн хүсэлтүүдийг авахаасаа өмнө харилцагчидтай сайтар ярилцаж, шаардлагатай баримтуудыг нь бүрдүүлэх талаар зөвлөж, ихэвчлэн зээл олгох боломжтой зээлийн хүсэлтүүдийг л хүлээж авдагтай холбоотой. Иймээс салбараас сайн нягталж авсан зээлийн хүсэлтийн дийлэнх нь хэрэгжих магадлалтай байдаг байна.

Эдгээрээс дүгнэхэд ЖДБ-ийн зээлийг банкууд олгох талаар нааштай бодлоготой хандаж, зээлийн хүсэлтийн талаас илүү хувийг бодитойгоор зээл болгон олгодог болох нь харагдана. Хэдийгээр харилцагчдын хувьд аль болох хүү багатай, урт хугацаатай зээл авах сонирхолтой ч банкууд өөрсдийн татан төвлөрүүлсэн хөрөнгөөр олгох зээлийн хугацаа ихэнхдээ 2 жил буюу 24 сар хүртэлх хугацаатай байдаг. Иймд бизнесийн өсч хөгжих урт хугацааны санхүүжилтийн хэрэгцээг хангахад төслийн зээл зайлшгүй

шаардлагатай бөгөөд одоогоор олгосон ЖДБ-ийн зээлийн 18% нь л таваас дээш жилийн урт хугацаатай зээл, 36% нь төслийн зээл байна.

2.2 Төслийн зээлүүд

ЖДБ-ийг дэмжих чиглэлд Засгийн газрын болон олон улсын донор байгууллагуудын хэд хэдэн төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээрийн ихэнх нь арилжааны банкуудаар дамжин олгогддог. Гэхдээ зээл олгох шийдвэрийг зарим төслийн хувьд тухайн төслийг хэрэгжүүлэгч нь өөрөө бие даан шийдвэрлэдэг бол зарим төслийн хувьд зээлийн хүсэлтийг хүлээн авах, судлах, олгох асуудалд санал өгөх гол үүргийг төсөлд оролцогч арилжааны банкууд гүйцэтгэдэг байна. Төслийн зээлүүдийн гол онцлог нь банкуудын бизнес зээлийг бодвол хүү бага, хугацаа урттай байдаг.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан

ЖДҮДС-ийн үндэс суурь нь анх 1992 онд Монгол улсын Засгийн газар болон АНУ-ийн Засгийн газрын байгуулсан “АНУ-аас Монгол улсад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тусламж үзүүлэх тухай” хэлэлцээрийн дагуу Худалдаа, Аж Үйлдвэрийн яаманд тавигдаж байсан. 2000 онд ЖДҮС нь ХАА, үйлдвэрлэлийн ЖДҮ-ийг дэмжих сан нэртэйгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны (ХХААХҮЯ) харъяанд шинэчлэн зохион байгуулагдсан. 2009 онд ХХААХҮЯ-ны харъяанд ЖДҮ-ийг хөгжүүлэх сан нэрээр дахин зохион байгуулагдаж, 2012-2014 онд Хөдөлмөрийн яамны харъяанд, 2014 оноос Аж үйлдвэрийн яамны харъяанд ажиллах болсон ба 2016 оноос буцаад ХХААХҮЯ-ны харъяанд шилжсэн.

Сангийн гол зорилго нь “*Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд*” оршино.

Төслийн зээлийг хамтран ажилладаг 10 банкаар олгодог ба зээл олгох шийдвэрийг ЖДҮДС-ийн зөвлөл гаргадаг. Зээлийн хүү болон хугацаа нь харьцангуй таатай нөхцөлтэй тул ЖДБ-үүд авахыг их эрмэлздэг.


Хүснэгт 8. ЖДҮДС-ийн төслийн зээлийн нөхцөл

Үзүүлэлт	Улаанбаатар	Аймаг	Бүс	Санхүүгийн түрээс
Дээд хэмжээ	200 сая төгрөг	100 сая төгрөг	200 сая төгрөгөөс дээш	200 сая төгрөгөөс дээш
Жилийн хүү	7%	7%	7%	10.8%
Зээлийн хугацаа	5 жил	5 жил	5 жил	5 жил
Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	1 жил	1 жил	1 жил	1 жил

Төслийг хүлээн авах байгууллага	Хот, дүүргийн ЗДТГ	Орон нутгийн ХХАА-н газар	ХХААХҮЯ, ЖДҮДС	ХХААХҮЯ, ЖДҮДС
---------------------------------	--------------------	---------------------------	----------------	----------------

Сангийн үйл ажиллагааны хүрээнд олгосон зээлийн нийт хэмжээ нь мөнгөн дүн болон тоогоор нийтэд нээлттэй биш. Харин төсөл хэрэгжсэн салбарын ажлын байр, салбарын мэдээлэл нь нийтэд ил тод мэдээлэгдэж байна.

Зураг 6. ЖДҮДС-ийн үйл ажиллагааны үр дүн (ажлын байр болон салбараар)



Эх сурвалж: ЖДҮДС вэбсайт

Сум хөгжүүлэх сан

Сум орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих зорилгоор 2011 оны Засгийн газрын 134 дүгээр тогтоолоор байгуулагдсан. Уг зээл нь 3 хувийн хүүтэй, 36 хүртэлх сарын хугацаатай, арилжааны банкаар дамждаггүй, орон нутаг өөрөө бие дааж шийдвэрлэдэг, сумын засаг дарга шууд гэрээ байгуулан олгодог, сум хөгжүүлэх сангаас шууд санхүүжүүлдэг, барьцаа хөрөнгийн баталгааг арилжааны банк шиг хатуу нөхцөлгүй, зээлийн гэрээг орлогын эх үүсвэрээс хамааруулан хийх боломжтой, улсын төсөвт эх үүсвэрийг буцаан татдаггүй учир байнга сумын хөгжилд тасралтгүй эргэх санхүүгийн эх үүсвэр бүрдсэн зэрэг онцлогтой. 2011-2014 онд улсын хэмжээнд нийт 84,0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс “Сум хөгжүүлэх санд” татан төвлөрүүлж 330 суманд хүн ам, эдийн засгийн боломжит нөхцөл байдлаас хамааруулж сумуудад хуваарилалт хийсэн.

Хүснэгт 9. Сум хөгжлийн сангийн хуваарилалт


Д/д	Хүн амын тоо	Сумын тоо	2011 он /сая.төг/	2012 он /сая.төг/	2013 он /сая.төг/	2014 он /сая.төг/	Нийт /сая.төг/
1	3000	169	50	50	50	18	168
2	3000-5000	98	60	60	60	24	204
3	5000+	31	75	75	75	30	255
4	Онцлох сум	7	110	110	110	30	360

5	Бор-Өндөр	1	-	205	205	122	532
6	Аймгийн төв	24	265	265	265	106	901

Эх сурвалж: Сангийн яам

2011-2015 оны хугацаанд 84.0 тэрбум төгрөгийг сум хөгжүүлэх сангийн өөрийн хөрөнгө, 39.0 тэрбум төгрөгийг эргэн төлөлтөөс төвлөрүүлж нийт 123.0 тэрбум төгрөгийн 23,181 төсөлд хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож шинээр 32,907 ажлын байр бий болж, 20,605 ажлын байр хадгалагдаж үлдсэн байна.

Хүснэгт 10. Сум хөгжүүлэх сангийн зээл мэдээлэл болон хамрагдсан салбарууд



Нийт 23,181 жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд зээл олгосноос 1.9% буюу 444 нь хуулийн этгээд /0.7% буюу 166 ХХК, 0.6% буюу 141 хоршоо, 0.6% буюу 137 нөхөрлөл/ 98.1% буюу 22,737 нь хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосон.

Хөрөнгө оруулалт хөгжлийн сан

Сангийн яам Хөрөнгө оруулалт хөгжлийн санг (ХОХС) 9 тэрбум төгрөгийн эх үүсвэртэйгээр 2007 онд байгуулсан. ХОХС нь 2 жилийн хугацаатай жилийн % хувийн хүүтэй зээлийг дөрвөн арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлсэн. Тус зээл нь шалгуур хангасан дотоодын компаниудад чиглэгдсэн бөгөөд нэг зээлдэгчид олгох дээд хязгаар нь 500 сая төгрөг байна.

2008 онд ХОХС нь бодлогын зээлийн нийт сангийн хэмжээг 30 тэрбум төгрөг болгож өсгөсөн. Энэхүү зээлийн загвар нь банкны зээлийн хүүгийн 50 хувийг татаас хэлбэрээр хөнгөлж байсан ба 15 хувиас доош хүүтэй зээлийг 5 жилийн хугацаатайгаар (дээд хязгааргүй) олгож байв.

ЖАЙКА-ийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл

Монгол улсын засгийн газар (Сангийн яам) болон Японы ОУХАБ-тай (ЖАЙКА) хамтран хэрэгжүүлж буй “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх,

байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай” зээлийн төсөл нь 2006 оноос хэрэгжиж эхэлсэн. Тус төслийн зорилго нь ЖДБ эрхлэгчид болон байгал орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн байгууллагуудад төслийн санхүүжилт олгох, төсөлд оролцогч арилжааны банкуудын урт хугацааны зээлийн судалгаа хийх чадавхийг сайжруулахад төслийн үндсэн үйл ажиллагаа чиглэгдэж байна. Төслийн I үе шат 2006-2010 (нийт санхүүжилт 25 сая ам.доллартай тэнцэх иен), II үе шат нь 2011-2016 онд (нийт санхүүжилт 50 сая ам.доллартай тэнцэх иен) хэрэгжсэн. Одоо төслийн III дахь үе шатыг (нийт санхүүжилт 100 сая ам.доллартай тэнцэх иен) явуулах талаар яригдаж байна. Уг төсөлд хамрагдсан нийт 8 арилжааны банкаар дамжуулан ЖДБ эрхлэгчдэд 3-10 жилийн хугацаатай жилийн 7-8 хувийн хүүтэй зээлийг олгодог.

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 781 аж ахуйн нэгжид 260 орчим тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд нийт 11 мянган ажлын байр шинээр нэмэгдсэн байна. Тус төсөлд 21 аймаг хамрагдсан бөгөөд нийт олгосон зээлийн 40 хувь нь орон нутгийн бизнес эрхлэгчид хамрагдсан байна. Үндсэн зээлийн эх үүсвэрээс нийт 310 аж ахуй нэгжид 113.5 тэрбум төгрөгийн зээл олгосон. Түүнчлэн эргэн төлөлтийн сангаас 442 аж ахуйн нэгжид 150 гаруй тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Хүснэгт 11. ЖАЙКА-ийн төслийн үйл ажиллагааны үр дүн

	Үзүүлэлт	I үе шат		II үе шат		Нийт
		Үндсэн эх үүсвэр	Эргэн төлөлтөөс	Үндсэн эх үүсвэр	Эргэн төлөлтөөс	
Олгосон зээлийн тоо	ЖДБ-ийн хөгжил	91	212	194	190	687
	Байгаль хамгаалал	18	27	36	13	94
	Нийт	109	239	230	203	781
Зээлийн дүн (сая ₮)	ЖДБ-ийн хөгжил	28,129	63,528	65,494	72,138	229,289
	Байгаль хамгаалал	5,937	10,034	13,981	4,490	34,442
	Нийт	34,066	73,562	79,475	76,628	263,731

Эх сурвалж: Хоёр үе шаттай зээлийн төсөл

Тус төслийн онцлог нь арилжааны банкууд сонгож, шалгаруулсан аж ахуйн нэгжүүдийн төслийн судалгааг хийж Төслийн Удирдах Хороонд танилцуулж шийдвэрлүүлдэг. Иймд банкууд өөрсдийн шаардлагыг хангах, эрсдэл даах

чадвартай харьцангуй сайн төслүүдийг сонгодог тул тус төслийн зээлийн эргэн төлөлт сайтай, амжилттай явж буй жишиг төслийн зээл болсон.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн” төсөл

Төслийн зорилго нь Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж (ААН)-үүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй (ХАА), хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол улсын эдийн засгийг солонгоруулах, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулахад чиглэгдэж байна.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд ашиглалтгүй байгаа мал аж ахуй болон ХАА-н бусад баялаг, нөөцийн нэмүү өртгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж дор дурдсан 4 үр дүнг бий болгох юм:

- 1) ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН, хоршоодод нэмүү өртгийн сүлжээ (НӨС)-г хөгжүүлэх хөрөнгө оруулалт хийгдэнэ;
- 2) Түүхий эд үйлдвэрлэгч, анхан шатны тордолт, хамгаалалт хийдэг малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэнэ;
- 3) ХАА-н бүтээгдэхүүнд суурилсан ААН-үүдийн маркетинг, чадвар, чадавхи дээшилнэ;
- 4) Монголын бүтээгдэхүүний брэнд хөгжүүлэлт.

Хүснэгт 12. Төслийн санхүүжилт

1	Санхүүжүүлэгч байгууллага	Азийн хөгжлийн банк																		
2	Санхүүжилтийн хэлбэр:	Хөнгөлөлттэй зээл																		
3	Төслийн нийт санхүүжилт: 61.0 сая ам.доллар, Үүнээс:	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 5%;">#</th> <th style="width: 75%;">Эх үүсвэр</th> <th style="width: 20%;">Дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>АХБ-ны Тусгай сан</td> <td>15,000.0</td> </tr> <tr> <td>2</td> <td>АХБ-ны Энгийн эх үүсвэр</td> <td>35,000.0</td> </tr> <tr> <td>3</td> <td>МУ-ын Засгийн газар</td> <td>1,000.0</td> </tr> <tr> <td>4</td> <td>Оролцогч аж ахуйн нэгжүүд</td> <td>10,000.0</td> </tr> <tr> <td colspan="2" style="text-align: right;">Нийт дүн</td> <td>61,000.0</td> </tr> </tbody> </table>	#	Эх үүсвэр	Дүн	1	АХБ-ны Тусгай сан	15,000.0	2	АХБ-ны Энгийн эх үүсвэр	35,000.0	3	МУ-ын Засгийн газар	1,000.0	4	Оролцогч аж ахуйн нэгжүүд	10,000.0	Нийт дүн		61,000.0
#	Эх үүсвэр	Дүн																		
1	АХБ-ны Тусгай сан	15,000.0																		
2	АХБ-ны Энгийн эх үүсвэр	35,000.0																		
3	МУ-ын Засгийн газар	1,000.0																		
4	Оролцогч аж ахуйн нэгжүүд	10,000.0																		
Нийт дүн		61,000.0																		
4	Эргэн төлөх хугацаа	25 жил																		
5	Төсөл хэрэгжих хугацаа	2016.03.01-2020.12.31																		
6	Ерөнхийлөн захирагч	Сангийн яам																		
7	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам																		
8	Хэрэгжих хугацаа	2016-2020																		

Эх сурвалж: Төслийн удирдах нэгж

Тус төсөл нь нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зорилгоор нийтдээ 42.0 сая ам.долларыг арилжааны банкуудаар дамжуулан арьс шир, ноос ноолуур, мах, сүү, оёдол, зөгийн аж ахуй, жимс жимсгэнэ, эрчимжсэн АА, хүлэмжийн АА, шилмэл малын үржил болон үрийн үйлдвэрлэлийн салбарын компаниудад 150,000-3 сая хүртэлх ам.доллар (эсвэл түүнтэй дүйцэх

төгрөг)-тай тэнцэх зээлийг 7 жил хүртэлх хугацаатай, эхний 3 жил хүртэлх хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэй, төгрөгийн зээлийг 8%, харин ам.долларын зээлийг 7%-иар олгохоор төлөвлөж байна. Мөн банкуудаар төсөл нь дэмжигдсэн боловч барьцаа хөрөнгө хүрэхгүй байгаа ЖДҮ-дэд төслөө хэрэгжүүлэх боломж олгож барьцаа хөрөнгийн 40-50% хувийг ЗГ-ын Зээлийн батлан даалтын санд хамруулах чиглэл барьж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Зээлийн батлан даалтын сангийн төсөл

Монгол Улсын “ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ” хууль 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан. Уг хуулийн хүрээнд 10 дугаар сарын 29-ний өдөр Зээлийн Батлан Даалтын Санг үүсгэн байгуулахаар Засгийн газар, ТББ, Олон улсын байгууллагын төлөөлөл үүсгэн байгуулах санамж бичигт гарын үсэг зурав. 2012 онд Сангийн дүрэм батлагдсанаар “Зээлийн Батлан Даалтын Сан” үүсгэн байгуулагдсан. Үндсэн зорилго нь Шуурхай, ил тод, найдвартай үйлчилгээгээр Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, улмаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах явдал юм.

Зээлийн батлан даалт хийх үйл ажиллагаа нь дараах процессоор явагддаг.

Зураг 7. Батлан даалт гаргах схем



Эх сурвалж: Зээлийн батлан даалтын сан

Зээлийн батлан даалтын сан нь 2017 онд Азийн хөгжлийн банкны 60 сая ам.долларын санхүүжилттэй “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төсөл хэрэгжиж эхэлсэн.

Төслийн зорилго нь зээл авахад барьцаа хөрөнгө нь хүрэлцдэггүй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хөнгөлөлттэй хүүтэй, урт хугацаатай, эх үүсвэртэй батлан даалттай зээл авах боломж бүрдүүлэх юм. Өнөөгийн байдлаар ХХБ банк болон Төрийн банктэй хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан.

Хүснэгт 13. “Эх үүсвэртэй батлан даалт” бүтээгдэхүүний нөхцөл

Зээлийн хэмжээ	Нэг тэрбум төгрөгөөс хэтрэхгүй
Зээлийн хугацаа	10 жилээс хэтрэхгүй
Зээлийн хүү /батлан даалтын хэмжээтэй уялдана/	Жилийн 12%-15%
Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	24 сараас хэтрэхгүй /Бизнесийн орлоготой уялдана/
Батлан даалтын хувь, хэмжээ	Олгох зээлийн 30-60% /500 сая төгрөгөөс хэтрэхгүй/
Батлан даалтын өргөдлийн хураамж	50.000 төгрөг /1 удаа төлнө/
Батлан даалтын шимтгэл /батлан даалтын хэмжээнээс хамаарна/	Жилийн 1% /Батлан даалтын үлдэгдлээс тооцож, жил бүр төлнө/

Зээлийн батлан даалтын удахгүй хэрэгжих энэ төсөлтэй хамтран ажиллахаар тодорхой шалгуурыг хангасан банкууд хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсгээ зурж байна. Одоогоор Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Хас банк, Хаан банкууд хамтрахаар болоод байна.

КфВ банкны ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл

Монгол улсын Засгийн газар 1994 онд Азийн хөгжлийн банктай, 1995 онд ХБНГУ-ын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголбанк КфВ банк болон АХБ-ны төслийн зээлийг банкуудад дамжуулан олгох үүрэгтэй оролцож байна. Эх үүсвэрийн хувьд Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай 8.7 сая еврогийн зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр хүлээн авсан. Төслийн зорилго нь Экспортын чиглэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих явдал юм.

Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 250,000 хүртэлх еврог 5 жилийн хугацаатай банкуудад дамжуулан олгодог. Монголбанк КфВ банкинд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд анх зээл авсанаас хойш нийт 2.5 сая еврог КфВ банкинд төлсөн. Ингэснээр энэхүү зээлийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 6.18 сая евро байна.

2016 оны эцсийн байдлаар хөтөлбөрийн эргэлтийн сангийн хөрөнгийн 88.4 хувийг дамжуулан олгосон байна. Үүний 42.6 (2.3 сая евро) хувийг ХХБ, 39.7 (2.2 сая евро) хувийг Голомт банк, 17.7 (0.9 сая евро) хувийг УБ хотын банк ашиглаж байна (Зураг 8).

Зураг 8. КфВ төслийн зээлийн эргэлтийн сангийн эх үүсвэрийн хуваарилалт



КфВ банкны төсөл манай улсад хэрэгжиж эхэлснээс хойш уг төсөлд нийт 158 ЖДҮ зээлд хамрагдаж, 66.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна. Тайлант улирлын эцсийн байдлаар 68 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 14.5 тэрбум төгрөг /5.46 сая евро/-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй дундаж зээлийн хэмжээ 213.7 сая төгрөг байна.

Оролцогч банкуудаас төслийн хүрээнд эцсийн зээлдэгчид төгрөгөөр дамжуулан олгосон зээлийн ЖДХ жилийн 13.6 хувь, еврогоор дамжуулан олгосон эх үүсвэрийн ЖДХ жилийн 8.5 хувьтай байна.

Хүснэгт 14. КфВ төслийн зээлд хамрагдсан ЖДҮ-ийн тоо, авсан зээлийн хэмжээ /оролцогч банкаар/

		Оролцогч банк	ААН-ийн тоо	Нийт олгосон зээлийн дүн /төгрөгөөр/	Нэг ААН-д оногдож буй зээлийн дүн	Зээлийн үлдэгдэлтэй байгаа ААН-ийн тоо	Зээлийн үлдэгдэл /төгрөгөөр/	Нэг ААН-д оногдож буй зээлийн дүн
2016.III	1	Монгол шуудан	27	12,801,456,326.40	474,128,012.09	-	-	-
	2	ХХБ	49	26,526,997,792.90	541,367,301.90	17	6,600,465,571.20	388,262,680.66
	3	Капитрон	27	14,373,129,771.00	532,338,139.67	-	-	-
	4	Голомт	33	7,527,868,880.00	228,117,238.79	33	5,276,246,008.10	159,886,242.67
	5	УБХБ	13	2,669,300,000.00	205,330,769.23	13	1,864,305,000.00	143,408,076.92
			НИЙТ	149	63,898,752,770.30	428,850,689.73	63	13,741,016,579.30
2016.IV	1	Монгол шуудан	27	12,801,456,326.40	474,128,012.09	-	-	-
	2	ХХБ	49	26,526,997,792.90	541,367,301.90	17	6,007,564,098.70	353,386,123.45
	3	Капитрон	27	14,373,129,771.00	532,338,139.67	-	-	-
	4	Голомт	33	7,527,868,880.00	228,117,238.79	29	4,573,511,741.30	157,707,301.42
	5	УБХБ	13	2,669,300,000.00	205,330,769.23	12	1,637,735,237.80	136,477,936.48
			НИЙТ	149	63,898,752,770.30	428,850,689.73	58	12,218,811,077.80
2017.I	1	Монгол шуудан	27	12,801,456,326.40	474,128,012.09	-	-	-
	2	ХХБ	50	26,626,997,792.90	532,539,955.86	18	6,184,764,431.20	343,598,023.96
	3	Капитрон	27	14,373,129,771.00	532,338,139.67	-	-	-
	4	Голомт	38	8,709,868,880.00	229,207,075.79	34	5,775,812,678.50	169,876,843.49
	5	УБХБ	16	3,599,300,000.00	224,956,250.00	16	2,567,735,237.80	160,483,452.36
			НИЙТ	158	66,110,752,770.30	418,422,485.89	68	14,528,312,347.50

КфВ төслийн ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр улиралын эцсийн байдлаар 716.4 мянган евро буюу 1.5 тэрбум төгрөг байна.

АХБ-ны Ажлын байр нэмэгдүүлэх (АБН) төслийн зээл

Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2154.0 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн. Гол зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэхэд оршино. Уг төслийн зээлийг Улаанбаатар хотын банк болон Голомт банк гэсэн 2 банкаар дамжуулан зээлдэж байна.

Төслийн эргэлтийн хөрөнгөд байршуулсан 3.2 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 97.5 хувийг Голомт банк, 2.5 хувийг Улаанбаатар хотын банкаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон байна. Банкуудын тайлангаас үзэхэд төслийн хүрээнд олгосон зээлийн үр дүнд зээл авсан ААН-үүд нийт 438 (Голомт банк 429, УБХБ 9) ажлын байр бий болгосон байна.

Энэ бүхнээс харахад арилжааны банкуудаар Засгийн газрын тусгай сангууд болон АХБ, ХБНГУ, Япон зэрэг улсуудаас үзүүлсэн хөнгөлөлттэй төслийн зээлүүдийг ЖДБ-д олгож байна. Эдгээр төслийн зээлийн нөхцөл нь ЖДБ-д тохирсон бага хүү, урт хугацаатай тул эрэлт нь их байдаг. Гэвч эх үүсвэрийн дутагдалтай байдал, нөгөө талаас ЖДБ-үүд төслийн зээлээс тавигддаг шаардлагыг төдийлөн сайн хангадаггүй тул зээл авсан ААН-ийн тоо хангалтгүй хэвээр л байна.

ГУРАВ. ЖДБ-ийн зээлийн тулгамдаж буй асуудлууд


Банкнаас олгож буй өөрсдийн зээлийн бүтээгдэхүүн болон бусад байгууллагын төслийн зээлүүдийг ЖДБ-д хүргэхэд нэлээдгүй асуудлууд тулгардаг. Эдгээрийг ерөнхийд нь зээлийн нөхцөл, зээлийн процесс болон харилцагчаас хамаарсан асуудлууд гэж ангилж болох юм.

3.1 Зээлийн нөхцөлтэй холбоотой бэрхшээлүүд

Зээлийн хүү болон хугацаа:

Монголын арилжааны банкуудаас олгож буй бизнесийн зээлийн талаар яригддаг хамгийн хүндрэлтэй асуудал бол зээлийн хүү өндөр, хугацаа богино тул бизнес эрхлэгчид эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх, бизнесээ өргөжүүлэх хөрөнгө оруулалтын зээл авах боломж хязгаарлагдмал байдаг явдал юм. Хэдийгээр Засгийн газар, Монгол банкны зүгээс 1990-ээд оноос хойш үнийг чөлөөлөх, инфляцийг бууруулах зэрэг шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч зээлийн хүү өндөр хэвээр л байна. Банкнуудын зээлийн нэрлэсэн хүү 2003-2008 онуудад дунджаар 27%, 2009-2016 онуудад тодорхой хэмжээгээр буурч дунджаар 19 хувьд хүрээд байна. 2007 оныг хүртэл банкуудын зээл болон хадгаламжийн хүүгийн маржин өндөр байсан бол 2008 оноос банкууд хүүгээр бус үйлчилгээ, бүтээгдэхүүнүүдээр өрсөлдөх болсон. Зээлийн хүү болон хадгаламжийн маржин тогтворжиж, зээлийн хүү дахин буурахад хүндрэлтэй болсон.

Зураг 9. Хүүгийн түвшин



Эх сурвалж: Монгол банкны Статистикийн бюллетень 2017

Нийлүүлэлт талаас нь үзвэл хадгаламжийн хүү өндөр байсаар байгаа нь түүнд суурилан тогтдог зээлийн хүүг бууруулах боломж олгохгүй байна. Нөгөө талаас Монгол банкны бодлогын хүү харьцангуй өндөр, Монгол банк болон Засгийн газрын бондын хүү өндөр тул банкууд эрсдэл болон зардал

ихтэй зээлд мөнгөө байршуулахын оронд эрсдэлгүй, хүү нь боломжийн өндөр төрийн үнэт цаасуудад оруулах сонирхол байдаг.

Банкны эх үүсвэрийг бүрдүүлэгч хадгаламжийн 90-ээс дээш хувь нь 1 жил хүртэлх хугацаат хадгаламж тул уг эх үүсвэрээр урт хугацаатай зээл олгох нь банкны хувьд эрсдэлтэй. Иймд дийлэнх зээл нь 2 жил хүртэлх бизнесийн зээл, эсвэл жил хүртэлх хэрэглээний зээлүүд байдаг.

Шигтгээ 7:


Бид нар харилцах, хадгаламж харилцагчаас татаад эргүүлээд зээл олгож байгаа. Гэтэл хадгаламжийн дээд хугацаа 2 жил, харилцах нь хугацаагүй. 2 жилийн хугацаатай хадгаламж маш бага хувийг эзэлж байгаа. Бага хугацаатай татсан эх үүсвэрээр, урт хугацаатай зээл олгох боломж бага.

Капитрон банк

Түүнчлэн, эрэлт талыг бүрдүүлэгч ЖДБ-үүд нь банкны хувьд зээлийн эрсдэл өндөртэй, зээлээ хугацаанд нь төлөхгүйгээс үүдэлтэй чанаргүй зээлд шилжих магадлал өндөр, тэдний талаарх санхүүгийн мэдээлэл хангалтгүй зэрэг шалтгаанаар банкууд ЖДБ-ийн зээл олголт бага байна.

Нөгөө талаас банкуудын гаднаас татсан бага хүүтэй, урт хугацаатай эх үүсвэрийн хэмжээ нь нийт хөрөнгийн 1/5 хувийг л эзэлдэг тул урт хугацаатай, бага хүүтэй зээлийг ЖДБ-үүдэд өгөхөд хүндрэлтэй байдаг.

Зураг 10. Банкны салбарын хөрөнгө болон өр төлбөрийн бүтэц (2016)



Эх сурвалж: Монгол банк

Ялангуяа, дэлхийн зах зээл дээрх голлох түүхий эдийн үнэ унасан, эдийн засгийн хямрал нүүрлэсэн, Засгийн газрын бондын төлбөр төлөхтэй холбоотой манай улсын зээлжих зэрэглэл буурсан нь банкуудын зээлжих зэрэглэлийг ч мөн бууруулж, улмаар банкууд гадны зах зээлээс эх үүсвэр татахад илүү өндөр хүү төлөх шаардлагатай болсон. Энэ нь эргээд

банкуудаас олгох зээлийн хэмжээг өсгөж, хүүг бууруулах боломжийг багасгаж байна.

Харин зээлийн эрэлтийг бүрдүүлэгч ЖДБ-үүдийн хувьд зээлийн хэмжээ их, хугацаа урт, хүү бага байвал тэдний бизнест тус дөхөм болно гэдэг. 2014 оны Монгол банкны ЖДБ-ийн судалгаагаар дийлэнх ЖДБ-үүдийн хүсэмжит зээлийн хүү нь жилийн 8%, хугацаа нь 5 жилээс урт байх явдал гэж хариулжээ.

Зээлийн барьцаа:

Барьцаа хөрөнгийн дутмаг байдал нь ЖДБ-үүд зээл авахад тулгардаг бас нэг гол бэрхшээл юм. Арилжааны банкуудын зүгээс ААН-үүдэд зээл олгохдоо барьцаалах хөрөнгөтэй байхыг шаарддаг ба хөрөнгийн үнэлгээ нь зээлийн дүнгээс нэлээд өндөр байх ёстой (ихэнхдээ энэ үнэлгээ 120 хувиас өндөр байдаг). Зээлийн хүсэлтүүдийг үнэлэхдээ банкууд эрсдлээ бодоод ирүүлсэн бизнес төсөл, ирээдүйд олох мөнгөн урсгал, байгууллагын үйл ажиллагаа зэргийг үнэлэхээс илүүтэйгээр барьцаа хөрөнгө нь чанартай эсэхэд л илүү анхаарал хандуулдаг. Иймээс гарааны бизнес болон ЖДБ-ийн дийлэнх нь барьцаа хөрөнгө ховор тул банкнаас зээл авч чаддаггүй. Банкуудын хувьд үл хөдлөх хөрөнгүүдийг л барьцаа болгох сонирхолтой.

Судалгаанд хамрагдсан зээлийн мэргэжилтнүүдээс барьцаа хөрөнгийн үнэлгээний талаар асуухад 64% нь банк харилцагчийн барьцаа хөрөнгийг хэт доогуур үнэлдэг гэсэн бол 30 хувь доогуур үнэлдэггүй учир нь банк эрсдэлээ бодно, үл хөдлөх хөрөнгийн зах зээл тогтворгүй, ЖДБ-үүд хөрөнгөө хэт өндөрөөр үнэлсэн зэрэгтэй холбоотой банкны үнэлгээ дооуур биш гэж хариулжээ.

Хэдийгээр “Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль” 2017 оны 03 сарын 01-ээс хойш хүчинтэй болсон ч банкууд хөдлөх хөрөнгийг барьцаалах тал дээр хойрго, болгоомжтой хандсан хэвээр л байна.

Шигтгээ 8:

Хөдлөх хөрөнгийн хуультай болсон ч бүрэн хэрэгжихгүй байна. Банкууд үүн дээр болгоомжтой хандаж байна. Банкууд дундын системтэй болчихсон, тэрэнд дээр хөдлөх хөрөнгийн барьцааг бүртгүүлдэг. Тэрэн дээр бүртгүүллээ гээд банкны барьцаа бүрэн хэрэгжихгүй байна. Жишээлбэл, автомашныг бүртгүүллээ гэсэн ч өөр зээл дээр тавьж, нэрийг шилжүүлэх асуудал үүсч болзошгүй. Тэр бүртгэл дээр анхны барьцаалагч гэж харагдахаас өөр бусад эрсдэл харагдахгүй байна. Хууль нь хэрэгжих гээд жигдрэх асуудал яваад байгаа.

Богд банк

Энэ нь хөдлөх болон эдийн бус хөрөнгийн нэгдсэн бүртгэлийн тогтолцоо, банк, банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд зээлд барьцаалсан хөрөнгүүдийн нэгдсэн мэдээллийн сан байдаггүй зэрэгтэй ч мөн холбоотой билээ.

3.2 Зээлийн процесстэй холбоотой асуудлууд

ЖДБ-ийнхэн зээл авахтай холбогдон гардаг дараагийн асуудлууд бол зээлийн хүсэлтээс гадна олон баримт бичиг бүрдүүлэхийг шаарддаг, хүнд сурталтай, зээлийн хүсэлтийг удаан судалдаг хэмээн ЖДБ-үүд банкуудыг шүүмжилдэг. Тэгвэл банк талаасаа энэ асуудалд хэрхэн ханддаг, зээлийн мэргэжилтнүүдийн зүгээс бодит байдалд ямар асуудлууд байдгийг анкетын судалгаагаар тодруулахыг зорьсон.

ЖДБ эрхлэгч зээл хүсэхээр ирэхдээ харилцагчийн менежер буюу зээлийн мэргэжилтэнтэй нэлээд олон уулзах шаардлагатай болдог. Учир нь харилцагч банкнаас тавигдаж буй бичиг баримтын болон бусад шаардлагыг мэддэггүйгээс хамаарч хэд хэдэн удаа банкинд ирэх хэрэгтэй болдог байна. Судалгаанаас харахад нэг харилцагчийн менежер дунджаар 4 харилцагчдад, хамгийн ихдээ 30 хамгийн багадаа 1 харилцагчдад тусалж байжээ. Нэг харилцагчид дунджаар 2.6 цаг, хамгийн ихдээ 9 цаг, хамгийн багадаа 1 цагийг тус тус зарцуулж байжээ.

Анхлан зээл авч буй ЖДБ эрхлэгчид дунджаар 15, давтан зээл авч байгаа тохиолдолд дунджаар 10 баримт бичгийг тус тус бүрдүүлж байгаа талаар дээр дурьдсан. Тэгвэл эдгээр баримт бичгүүдийг ЖДБ-үүд дунджаар 5 өдөр, хамгийн ихдээ 18 өдөр, багадаа 2 өдөр бүрдүүлдэг байна. Зээлийн баримт бичиг бүрдүүлж буй дундаж хугацааг банкуудаар авч үзвэл Хас банк, Улаанбаатар хотын банкны баримт бичгийг бүрдүүлэхэд хамгийн их хугацаа харин Капитрон банк, Ариг банк, Богд банк, Голомт банкны баримт бичгийг бүрдүүлэхэд хамгийн бага хугацаа зарцуулдаг байна.

Зураг 11. ЖДБ-үүдийн зээлийн материал бүрдүүлж буй хугацаа, банкаар

Банкны нэр	Бичиг баримт бүрдүүлэх хугацаа /өдөр/		
	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага
Хас банк	11	18	3
Улаанбаатар хотын банк	8	12	5
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	7	7	7
ХХБанк	7	8	4
Хаан банк	5	8	3

Чингис хаан банк	5	5	5
Капитал банк	5	5	5
Төрийн банк	4	8	2
Капитрон банк	3	4	3
Ариг банк	3	5	2
Богд банк	3	3	3
Голомт банк	3	6	2
Нийт	5	18	2

Зээл хүсэж буй байгууллага, бүрдүүлэх шаардлагатай материалын жагсаалтаас хамаарч банк тус бүрт материал бүрдүүлэхэд хамгийн их цаг авдаг бичиг баримтууд байх боловч нийтлэг байдлаар дараах материалыг бүрдүүлэхэд хамгийн их уддаг байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, түүний баталгаажуулалтын материалыг бүрдүүлэх (Ялангуяа орлого нотлох баримтууд)
2. Төрийн байгууллагаас авах шаардлагатай материалууд (Татвар, үл хөдлөх хөрөнгө) бүрдүүлэхэд хамгийн их цаг авдаг байна.

Нөгөө талаас зарим банкны мэргэжилтнүүд банкны зүгээс, ялангуяа төслийн зээлүүдийн зүгээс ЖДБ-д дарамт чирэгдэл болох баримтуудыг ч шаарддаг гэж хариулсан.

Шигтгээ 9:

Одоогоор ЖДБ-ийг дэмжье гэсэн мөртлөө, дааж давшгүй өндөр шаардлага тавиад байна. Энэ шаардлагыг хангахад өндөр зардалтай байдаг. Жишээлбэл, байгаль орчны үнэлгээ, ТЭЗҮ бичсэн төсөл шаарддаг. Жижигхэн үйлдвэрлэл эрхлэгчид, жишээлэл 20 сая төгрөгний зээл авахад 2 сая төгрөгөөр төсөл бичүүлнэ, ТЭЗҮ хийлгэхэд 500-600 мянган төгрөг хамгийн багадаа болно. Байгаль орчны үнэлгээ бүр бизнес болчихсон. 1 сая, 3 сая төгрөг гээд байж байдаг. Ингэхээр жижиг зээл авах гэж байгаа хүндрэлтэй. Бизнес нь амжилттай хэрэгжих, ашиг олох боломжуудыг бүгдийг хаачихдаг. Үүнийг төслийн эх үүсвэр өгч байгаа газрууд түлхүү анхаарах хэрэгтэй

Төрийн банк

ЖДБ-тэй холбоотой зээлийн материалыг бүрдүүлж, зээл олгох хүртэл харилцагчийн менежерүүдийн 30.3% нь 3 хүртэлх удаа, 63.6% нь 3-5 удаа харилцагчтай уулздаг байна. Зээлийн хүсэлт ирсэний дараа харилцагчийн менежерүүд зээлийн материалын бүрэн бүтэн байдлыг шалгахад дунджаар 47 минут хамгийн ихдээ 210 минут, хамгийн багадаа 10 минутыг тус тус зарцуулдаг байна. Харилцагчийн менежерийн ажиллаж буй нэгжээр нь харвал зээлийн төвд ажиллагсдын хувьд бусад төв, салбаруудтай харьцуулахад зээлийн материалын бүрэн бүтэн байдлыг шалгахад зарцуулж буй хугацаа харьцангуй өндөр байна.

Банкуудад ирж буй ЖДБ-ийн зээлийн хүсэлтийн материал 20 хүртэлх хувиар дутуу ирдэг гэж 12.0%, 20-40% дутуу ирдэг гэж 39.4%, 40-70% дутуу ирдэг гэж 42.4% нь хариулжээ. Харин үлдсэн 6.1% нь бүрдүүлэх ёстой нийт материалын 70-аас дээш хувь нь дутуу ирдэг гэжээ. Үүнээс үзвэл ЖДБ-ийн зээл авахаар материал бүрдүүлэгчид шаардлагатай материалуудыг дутуу ирүүлдэг байна. Эдгээр дутуу материал бүрдүүлж ирсэн ЖДБ-ийн зээл авах хүсэлтэй харилцагчдад дутуу материалыг нь бүрдүүлэхэд нь тусалдаг гэж 10 хариулагч тутмын 6, утсаар ярьж хэлдэг гэж 5, уулзаж тайлбарладаг гэж 1 нь тус тус хариулжээ.

ЖДБ-ийн ирүүлсэн зээлийн хүсэлтийн дагуу холбогдох шинжилгээ, судалгааг хийхэд дунджаар 63 цаг (8 ажлын өдөр), хамгийн ихдээ 192 цаг (24 ажлын өдөр) хамгийн багадаа 3 цаг зарцуулдаг байна. Зээлийн төвд ажилладаг харилцагчийн менежерүүдийн хувьд зээлийн хүсэлтэд холбогдлох судалгаа шинжилгээг хийхэд дунджаар 71 цаг (9 ажлын өдөр) зарцуулж байгаа нь хамгийн өндөр байна.

Хүснэгт 15. Зээлийн материалын бүрэн бүтэн байдал, холбогдох судалгаа шинжилгээг хийхэд зарцуулж буй хугацаа, ажиллаж буй төв, салбараар

Үзүүлэлт		Таны дараах нэгжийн алинд ажилладаг вэ?				
		ЖДБ-ийн төв	Зээлийн төв	Салбар	Тооцооны төв	Нийт дүн
		Тоо	Тоо	Тоо	Тоо	Тоо Хувь
Зээл хүсэж ирсэн харилцагчтай зээл олгох хүртэлх хугацаанд уулзах давтамж	3 хүртэлх удаа	1	5	2	2	10 30.3
	3-5 удаа	0	8	8	5	21 63.6
	5-7 удаа	1	0	0	1	2 6.1
Зээлийн материалын бүрэн бүтэн байдлыг шалгахад зарцуулж буй хугацаа /минут/	Дундаж	40	55	44	39	47
	Хамгийн их	60	210	180	60	210
	Хамгийн бага	20	25	15	10	10
Зээлийн хүсэлтийн дагуу холбогдох шинжилгээ, судалгааг хийхэд зарцуулж буй хугацаа /цаг/	Дундаж	60	71	52	67	63
	Хамгийн их	72	96	96	192	192
	Хамгийн бага	48	24	3	4	3

Эдгээрийг дүгнэхэд банкнаас анхлан зээл авагч ЖДБ эрхлэгч нь дунджаар 15, давтан зээл авахад 10 орчим баримт бичгийг банкинд бүрдүүлж өгөх шаардлагатай ба банкны зээлийн мэргэжилтэнтэй ойролцоогоор 3-5 удаа уулзаж, ойролцоогоор 5 өдрийг баримт бүрдүүлэхэд зарцуулдаг байна.


Харин бүрдүүлсэн баримт бичгийн бүрдүүлэлтийг зээлийн мэргэжилтэн нь дунджаар 47 минутад шалгаж нягталдаг. Зээлийн хүсэлтийг судалж, зээлийн хороонд өгөх хүртэл зөвхөн баримт бичгийг судлахад дунджаар 8 өдрийг зээлийн менежер зарцуулдаг. Зээлийн бүрдүүлэлт дотроос банкны эрсдэлээ бууруулах үүднээс барьцаа хөрөнгө буюу үл хөдлөх хөрөнгөөд гол анхаарал хандуулдаг. Хэдийгээр хөдлөх хөрөнгийн барьцааны хууль батлагдсан ч хэрэгжилт нь төдийлөн сайн биш байна. Энэ бүхнээс харахад банкны хувьд хадгаламж, бусад эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг аль болох эрсдэл багатай, зээлээ төлөх чадвартай буюу найдвартай харилцагчид зээл болгон өгөх сонирхолтой байх нь зүйн хэрэг. Харин зээлийн эрэлт талыг бүрдүүлэгч бизнес эрхлэгчид маань банкуудын шаардлагыг хэр хангаж байна гэдэг нь дараагийн нэг бэрхшээл юм.

3.3 Харилцагчаас хамааралтай асуудлууд

ЖДБ-үүд зээл олддоггүй, банкууд барьцаа хөрөнгийг нь хэт доогуур үнэлдэг, банкны зээлийн хүү өндөр зэргээр банкуудыг олонтаа шүүмжилдэг боловч өөрсдөө банкны шаардлагыг хэр хангаж ажиллаж чаддаг талаар төдийлөн их ярьдаггүй. Иймд зээлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэгч банк талаас харилцагчидтай холбоотой ямар асуудлууд тулгардаг, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авбал зохилтой гэж үзэж байгаа талаар банкны удирдлага болон зээлийн мэргэжилтнүүдээс тодруулсан.

Зээлийн мэргэжилтнүүдийн хувьд зээлийн хүсэлтийг судлахад хамгийн их цаг зарцуулдаг хүчин зүйлсээр мөнгөн урсгалын тооцоолол (42.4%), бичиг баримтын бүрдүүлэлт (33.3%), бизнес төлөвлөгөөний боловсруулалт (30.3%) гэж нэрлэжээ. Иймд эдгээр материалыг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх эсвэл зээлийн зарим шаардлагыг зөөлрүүлэх нь зүйтэй гэсэн саналууд байгааг дурдах нь зүйтэй.

Зураг 12. Зээлийн хүсэлтийг судлахад хамгийн их цаг зарцуулдаг хүчин зүйлс



Түүнчлэн, ЖДБ-ийн *санхүүгийн тайлангууд үнэн зөв биш* байдаг нь тухайн зээлийг судлахад хамгийн их хүндрэл учруулдаг гэж нийт хариулагсдын 72.7% нь үзжээ. ЖДБ-үүдийн дийлэнх нь өөрийн гэсэн нягтлан бодогчгүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлэн татвар, НДШ бага төлөх зорилгоор алдагдалтай санхүүгийн тайланг хөлсний нягтлан бодогч нараар гаргуулдаг. Энэ нь эргээд банкнаас зээл авахад нь ялангуяа сайн нөхцөлтэй төслийн зээл авахад нь ихээхэн хүндрэл учруулдаг.


Шигтгээ 10:

Гол нь орлого нотлох баримт байдаггүйд асуудал байгаа. Том компаниуд санхүүгийн тайлангаа гаргаад явчихдаг. Харин ЖДБ эрхлэгчдэд бодит санхүүгийн тайлан байхгүй. Ялангуяа гадны төслүүд заавал санхүүгийн тайлан гэдэг, гэтэл ЖДБ-ийн тайлангууд нь дандаа алдагдалтай байдаг. Бодит байдал дээр төлсөн зээл, авсан тоног төхөөрөмж зэргийг харахаар боломжийн орлоготой байсан нь харагдаад байдаг. ЖДБ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлээд, санхүүгийн тайлангаа бодитой болгох талаасаа зөвлөгөө шаардлагатай байдаг.

Капитрон банк

Санхүүгийн тайлангаас гадна ЖДБ-үүд бүрдүүлэх ёстой баримт бичгүүдээс компани/төслийнхөө мөнгөн урсгалын тооцоог хийх, төслийн үр ашгийг үнэлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийхдээ анхаарч ажиллах нь зүйтэй хэмээн банкны мэргэжилтнүүд үзэж байв. Өөрөөр хэлбэл эдгээр 3 тооцооллыг хийхдээ мэргэжлийн түвшинд сайн хийж чадахгүй байна гэж хариулсан.

Зураг 13. Зээлийн бичиг баримт бүрдүүлэхэд хийж чадахгүй байгаа эсвэл ойлгохгүй байгаа зүйлс



Эндээс харахад ЖДБ-үүдийн санхүүгийн удирдлагын талаарх мэдлэг ур чадвар дутмаг байгаа нь тодорхой байна. Аливаа төслийн хувьд хөрөнгө оруулагчид буюу банкуудын зүгээс төсөл үр ашигтай эсэх, үр ашигтайг нотлох мөнгөн урсгалын тооцоо байгаа эсэхийг чухалчилан харах нь зүйн хэрэг. Харин энэ байдлыг бизнес эрхлэгчид мэддэггүй, эсвэл төдийлөн ойлгодоггүй.

Шигтгээ 11:

Хүмүүс зээл хүсэж ирэхдээ хамгийн анхан шатны зээлээ ямар орлогоос хэрхэн эргүүлэн төлөх вэ, мөнгөн урсгал ямар байх вэ, баланс ямар байх вэ гэдэг дээр ерөөсөө анхаарал хандуулдаггүй. Яг юунаас яаж мөнгө бий болгож байгаа вэ, ямар хугацаанд энэ мөнгө бий болох, цикл, авлага хэд хоногийн дараа орж ирэх вэ гэдэг тооцоо хийж чаддахгүй байна.

Үндэсний хөрөнгө оруулалтын банк

Иймд банкны мэргэжилтнүүдийн зүгээс зөвлөхөд ЖДБ-үүд нь цаашид санхүүгийн нэг тайлантай болж (73%), бизнес төлөвлөгөөгөө сайн боловсруулж (42%), мөнгөн урсгал төслийн тооцоогоо сайн (39%) хийвэл зээл хариуцсан банкны ажилтны хувьд зээл олгохтой холбоотой процесс илүү хөнгөвчлөгдөж, хялбар болно гэж хариулжээ.

ДӨРӨВ. ЖДБ-ийн зээлийн цаашдын хандлага

4.1 Хууль эрхзүйн орчин

ЖДҮ-ийн хуулийн шинэчлэл:

2007 онд УИХ-аар батлагдсан ЖДҮ-ийн хуулийн заалтууд, ялангуяа ЖДБ-ийн ангиллын шалгуурууд өнөөдрийн шаардлагыг хангахгүй байна.

Шигтгээ 12:

Манай банк 3 тэрбум төгрөг хүртэлх зээлийг ЖДБ-ийн зээл гэж үздэг. Мөн ажилчдын тоо бол мэдээж нөлөөтэй. Хуульд заасан жилийн борлуулалтын орлого болох 1.5 тэрбум төгрөг нь бага юм болов уу гэж бодоод байна. Нарантуул зах дээр наймаа хийж байгаа хувь хүн гэхэд л сарын 300-500 сая борлуулалттай. Тэгсэн мөртлөө тэр хүн ЖДБ эрхлэгч аж ахуйн нэгж биш, хувиараа яваад байдаг гэх мэт бодох юмнууд байгаа

Худалдаа хөгжлийн банк

Судалгаанд хамрагдсан банкны удирдах ажилтнууд бичил, жижиг, дунд, гарааны бизнесүүдийн тодорхойлолтыг сайжруулах шаардлагатай хэмээсэн. Энэ асуудлыг шийдвэрлэх тодорхой заалтууд, мөн ЖДБ-ийн санхүүжилттэй холбоотой асуудлуудыг ЖДҮ-ийн хуулийн шинэчилсэн найруулгад тодорхой хэмжээгээх тусгахаар хэлэлцэж байна. Уг хуулийн шинэчилсэн найруулгыг 2018 онд УИХ-аар хэлэлцэх төлөвтэй байна.

2018 онд хэлэлцэгдэж батлагдах бас нэг чухал хууль бол “Банкны тухай” хуулийн шинэчилсэн найруулга юм.

Банкны тухай хуулийн шинэчлэл

Монгол Улсын Засгийн газраас Олон Улсын Валютын Сан(ОУВС)-тай тус сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах урьдчилсан тохиролцоонд хүрч ⁶, энэхүү хөтөлбөрийн хүрээнд банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, банкны үйл ажиллагааны эрсдлийг бууруулах зорилгоор банкны хяналт шалгалтыг олон улсын сайн туршлагад нийцүүлэн сайжруулах тодорхой саналыг өгсөн. Иймд “Банкны хяналт шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах” зорилгоор шинэчилсэн найруулгыг мэргэжлийн байгууллага, хүмүүс хэлэлцэн сайжруулж байна. ОУВС-аас өгсөн саналуудад банкны үйл ажиллагааны эрсдлийн түвшин тодорхой зэрэгт хүрсэн тохиолдолд банкны хяналт шалгалтын урьдчилан сэргийлэх оролцоог бий болгох, банкны удирдлага, хувьцаа эзэмшигчээс банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхийг Монголбанк шаардах эрхтэй байх, зарим

⁶ <http://zasag.mn/news/view/16277>

тохиолдолд Монголбанкнаас аудитын байгууллагыг сонгож, банкинд аудит хийлгэх эрхтэй байх, банкны хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад тавигдах шалгуурыг сайжруулах, банкны холбогдох этгээдийн тодорхойлолтыг илүү тодорхой болгох зэрэг асуудлыг олон улсын шилдэг туршлага, шийдэл, зарчимд нийцүүлэх зэрэг саналууд багтсан. Эдгээрийг харгалзан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, УИХ-аар батлуулахаар тохирсон.

Энэ хүрээнд харгалзаж үзэх нэг үнэлгээ бол ОУВС-ийн шаардлагын дагуу олон улсын хөндлөнгийн байгууллагаар арилжааны 14 банкинд хийлгэсэн “Активын чанарын үнэлгээ”-ний үр дүн юм. Уг үнэлгээг 2017 оны 08 сараас хийсэн бөгөөд үр дүн нь нийтэд хараахан танилцуулагдаагүй байна. Үнэлгээний хүрээнд банкуудын бодлого, журмын үнэлгээ, зээлийн жагсаалт баталгаажуулах, түүвэр хийх, зээлийн хувийн хэргийг шалгах, барьцаа болон 3 дугаар түвшний активын хөрөнгийн үнэлгээ хийх, бүлгийн үнэлгээний ажлууд хийгдсэн.

Банкны удирдлагуудын хэлж буйгаар активын чанарын үнэлгээ хийгдэж, хуулийг энэ дагуу шинэчлэн найруулснаар ирэх жилүүдээс барьцаа хөрөнгийг банкууд бус харин олон улсын стандартын дагуу үнэлгээ хийдэг хөндлөнгийн үнэлгээний компаниуд хийж эхлэхээр байна. Гэхдээ ийм үнэлгээний компани одоогоор тун цөөн тул үнэлгээний компаниудыг чадавхижуулахад тодорхой хугацаа орно. Ингэснээр барьцаа хөрөнгийн үнэлгээ улам ч хатуу болох магадлалтай байна. Энэ нь ЖДБ-үүдэд хүнд тусах талтай.

Шигтгээ 13:

Активын чанарын үнэлгээ гээд ОУВС-аас хийж байгаа ажил нь өөр асуудал ярьж байна. Тэднийхээр бол бид нар барьцаа хөрөнгийн үнэлгээг харьцангуй гайгүй өндөр үнэлдэг гэж үзчихээд байна. Тэгээд банкууд өөрсдөө үнэлэхгүй, хөндлөнгийн байгууллагуудаар олон улсын стандартын дагуу үнэлүүлэхэд банкуудын одоогийн үнэлж байгаагаас буурдаг асуудал гарч байна.

Хас банк

Шигтгээ 14:

Активын чанарын үнэлгээг хэрэгжүүлснээр, ЖДБ эрхлэгчдэд ашигтай байх тал бага харагдаад байгаа. Жишээлбэл, активын чанарын үнэлгээнд хоёр маргаан дагуулсан асуудал байгаа нь татварын тайланг авах болон барьцаа хөрөнгийн үнэлгээ. Барьцаа хөрөнгийн үнэлгээг ОУ-ын стандартаар хийвэл зээл олгох өртөг маань нэмэгдэнэ. Үнэлгээний стандартыг хангахгүй байх, зарим төрлийн үнэлгээ хийгдэхгүй байх барьцаанууд, мөн барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх зардал гээд асуудал байгаа. Уг зардал шууд харилцагчид дээр очихгүй, гэхдээ

банкны зардал нь зээлийн хүүн дээр нэмэгдэх, барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх систем шинэчилэгдэх гэх мэт асуудал үүсэх байх.

Богд банк

Хэрэв олон улсын стандартыг баримталбал ЖДБ-үүдийн хувьд санхүүгийн тайлангаа үнэн зөв болгож, банкинд татварын тайлангаа өгөх шаардлага урган гарна. Ингэснээр татварт зориулан “0 баланс”-тай тайлан гаргадаг дийлэнх ЖДБ нь банкны зээл авах боломжгүй болно. Учир нь банкууд одоогоор санхүүгийн тайлангүй, эсвэл “0 баланс”-тай ААН-үүдийн дотооддоо хөтөлдөг “хар дэвтэр”-ийг (албан бус бүртгэл хөтлөлт) үндэслэн зээл олгож байгаа нь шинэ нөхцөл байдалд тохирохгүй болно. Гэхдээ уг шинэчлэл хэрэгжтэл 1-2 жил зарцуулагдах хандлагатай тул ЖДБ-үүд одооноос энэ нөхцөл байдлыг ухамсарлаж, санхүүгийн хувьд цэвэрших шаардлагатай байна.

4.2 Банкуудын хүрээнд гарах өөрчлөлт

Дэлхийн Банкны 2014 оны судалгаанд Монгол Улс зээл авах хялбар байдлаараа 189 орноос 61-р байранд жагссан бөгөөд 100 онооноос 55 оноо авч, Зүүн болон Номхон далайн орнуудын дундаж (48,6 оноо)-тай ойролцоо дүн авчээ (World Bank, 2014). Эндээс харахад банкнаас зээл авахад бусад ижил түвшний улсуудтай адил байна. Гэхдээ энэ үзүүлэлтийг илүү сайжруулах хэрэгцээ шаардлага бас боломж байна. Энэ чиглэлээр банкууд ч тодорхой алхмуудыг хийж эхэлсэн.

Харилцагчаа бэлддэг банкууд:

Нэгэнт ЖДБ-ийн чадавхи сул байгаа нь банкуудын үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй тул ирээдүйн томоохон харилцагчдыг банкууд өөрсдөө бэлдэх хэрэгтэй гэдгийг тодорхой хэмжээгээр ухамсарлах болсон. Энэ нь нэг талаар нийгмийн хариуцлага мэт боловч өөрсдийн ирээдүйн том харилцагчдаа бэлдэх гэсэн давхар ач холбогдолтой.

Шигтгээ 15:

Жишээлбэл, бид 5 компанид сургалт явуулахад уг 5 компани 5 өөр асуудалтай байсан. Эхний компанид зээл шаардлагагүй боловч ханшийн эрсдэлээс сэргийлэх шаардлагатай байсан. Нөгөөх нь хүний нөөцийн асуудалтай, харин гуравдах нь бүтэц зохион байгуулалтын асуудалтай г.м харилцагч нар өөр өөр зөвлөгөө авах шаардлагатай болчихдог. Бодлого маань өөрөө зөвлөгөөгөөр үнэнч харилцааг бий болгоё, үнэнч харилцааг бий болгосноор нэг өдөр манай банкны харилцагч болж ирнэ гэж үзэж байгаа.

Голомт банк

Энэ үүднээс иргэд болон ЖДБ-үүдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар банкууд томохон тоглогчид болж байна. Харилцагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үүднээс Голомт, Хаан, ХХБ, Хас зэрэг банкууд вэбсайтдаа ЖДҮ-д зориулсан Бизнесийн удирдлагын цогц шийдэл, Санхүүгийн зөвлөгөө зэрэг булангуудыг ажиллуулан бизнесийн удирдлага, санхүү, хүний нөөц зэрэг чиглэлээр тодорхой зөвлөгөөнүүдийг өгдөг, мөн Бизнес инкубатор төвөөрөө дамжуулан бодит сургалт, зөвлөгөөг бүлгээр болон ганцаарчилсан байдлаар өгдөг болсон. Энэ хандлага цаашид улам бүр банкны тогтолцоог бүхэлд нь хамарсан шинжтэй болно.

Өртгийн сүлжээний санхүүжилт:

Өдийг хүртэл банкууд зээлийг тухай тухайн ЖДБ-үүдэд л дан дангаар олгодог байсан. Гэхдээ жижиг эдийн засагтай манай улсын хувьд өртгийн сүлжээнд оролцогчдыг бүхэлд нь харж, хамтын ажиллагаа, уялдааг хангаж өгөх хэрэгтэй гэдгийг банкууд ч тодорхой хэмжээгээр ажиглаж эхэлсэн. Энэ үүднээс өртгийн сүлжээнд багтах харилцагчдын зээлийг цогцоор нь үнэлж, ганц тоглогчид бус бусад хамааралтай өртгийн сүлжээний оролцогчдыг хамтаар нь дэмжиж байж бүгд зээлээ төлөх боломжтой, ашигтай ажиллах юм байна гэдгийг банкууд ухамсарлаж байгаа нь ажиглагдсан. Мөн банкны зүгээс харилцагчдаа хооронд нь танилцуулах, хамтын ажиллагааг нь идэвхижүүлэх чиглэлд ажиллана гэдгээ Голомт, Хаан зэрэг томоохон банкууд илэрхийлж байв. Ингэснээр ЖДБ-үүд хамтаар хөгжинө, банкны хувьд зээлээ найдвартай төлдөг сайн харилцагчидтай байж, бизнесүүд томрохын хэрээр банкнаас авах үйлчилгээ нь ч нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.

Уламжлалт бус шинэлэг бүтээгдэхүүнүүд:

Банкууд 1990-2010 он хүртэл хадгаламж, зээл гэсэн уламжлалт бүтээгдэхүүний хүү, урамшууллаар өрсөлддөг байсан бол сүүлийн жилүүдэд харилцагчдын нөхцөл байдал, зан төлөв, тэдний эрэлт хэрэгцээ, зах зээлийн хандлага, технологийн дэвшил зэрэг олон хүчин зүйлсийг харалзан үзэж илүү шинэлэг, нийцтэй бүтээгдэхүүнүүдийг бий болгох тал дээр өрсөлдөх болсон. Энэ нь харилцагчдын хувьд банкны үйлчилгээний хүртээмж, чанар, үнийг бууруулах сайн талтай.

Шигтгээ 16:

Уламжлалт арга барил эрс өөрчилөгдөх гээд байна. Ингэж байж банкууд амьд үлдэнэ. Манайх зөвхөн зээл гэхээсээ илүү Synergy үүсгэсэн зүйлийг бий болгож байна. Стандарт бүтээгдэхүүнээс илүү тухайн харилцагчийн эрэлт хэрэгцээнд суурилсан зүйлийг санал болгох хэрэгтэй байна.

Голомт банк

Энэ хандлага нь хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгөний зээлийн аль алины хувьд хэрэгжихээр харагдаж байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын зээл олгоход банкуудад урт хугацаат, хүү багатай гадны санхүүжилт шаардлагатай. Энэ тал дээр зарим банкууд БНХАУ, БНСУ-ын банк зэрэг санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах эхлэлийг тавьж байна. Мөн Японы ЖАЙКА-ийн Хоёр үе шатат зээлийн системд тулгуурлан байгуулахаар яригдаж буй Тусгай зориулалтын санхүүгийн байгууллага (хөрөнгө оруулалтын сан маягийн) хэрэгжвэл хамтын санхүүжилт практикт илүү нэвтэрнэ. Азийн хөгжлийн банкны төслийн шугамаар хэрэгжиж эхлэх гэж буй Зээлийн батлан даалтын сангийн шинэ үйл ажиллагаа ч гэсэн энэхүү хамтарсан санхүүжилтийн нэгэн хэлбэр болж байна. Түүнчлэн, тодорхой төслүүдийг санхүүжүүлэхдээ банкууд барьцаа хөрөнгө л шаардаад байх бус харин уг төслийн үйл ажиллагааны ирээдүйн мөнгөн урсгалыг нь барьцаалж зээл олгодог төслийн санхүүжилтийн хэлбэрийг ч банкууд сонирхож, энэ чиглэлд зээлийн мэргэжилтнүүдээ бэлдэж, ийм төрлийн бүтээгдэхүүн шинээр гаргах боломж нээлттэй байна.

Эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хувьд банкууд ЖДБ-ийн шинээр авч буй тоног төхөөрөмжийг нь барьцаалдаг, авлагыг барьцаалдаг гэх мэт шинэ санхүүжилтийн хэлбэрүүд бий болгож байна. Жишээ нь ХХБ, Капитал зэрэг банкууд Оюутолгой ХХК-ийн нэхэмжлэх дээр үндэслэн авлага барьцаалсан зээлийг олгож эхэлсэн. Мөн цаашид хууль эрхзүйн орчин, хэрэгжилтийн механизм нь ажиллаад, даатгал, үнэлгээ, төрийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа нь сайжирвал агуулах барьцаалсан зээл зэрэг шинэ хэлбэрүүд хэрэгжих боломжтойг уулзсан банкны удирдлагууд хэлж байв.

Манай ЖДБ-ийн хувьд тулгардаг нэг том асуудал бол авлагын удирдлага байдаг. Том, дунд, жижиг бүхий л ААН-үүдэд төлөгдөөгүй авлага их байдаг нь тэдний цаашдын үйл ажиллагаа, хөрвөх чадвар, зээлээ төлөх чадварт сөргөөр нөлөөлдөг. Энэ асуудлыг шийдвэрлэх гарцуудын нэг нь факторингийн үйлчилгээ юм. Факторинг үйлчилгээг нэвтрүүлэх хууль эрхзүйн судалгааг Европын Сэргээн Босголтын Банкнаас одоо хийж байгаа бөгөөд эрхзүйн орчинг нь сайжруулж, хэрэгжүүлэх боломжууд нь бүрдвэл ирэх 3 жилд энэ төрлийн үйлчилгээг банкууд үзүүлж эхлэх боломж бүрдэх болов уу. Учир нь өнөөгийн нөхцөл байдалд хувийн хэвшлийн бизнесүүдтэй тулж ажилладаг, тэдний талаарх мэдээллийг хамгийн сайн мэддэг хийгээд, бүгдэд нь зээл өгсөн, данс эзэмшүүлдэг байгууллага бол банкууд билээ. Энэхүү давуу тал дээрээ суурилан факторингийн үйлчилгээг эхний ээлжинд банкууд, эсвэл тэдний байгуулах охин компаниуд гүйцэтгэх боломжтой.

Технологийн дэвшилтэй банкууд ч мөн хөл нийлүүлэн алхаж байна. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвхөн банкууд дангаараа үзүүлэх бус финтекүүдтэй хамтрах хандлага, сонирхол байгааг уулзсан банкны удирдлагууд илэрхийлж байв. Зээлийн бүтээгдэхүүнүүдийн хувьд ч энэ хандлага мөн ажиглагдах боломжтой. Энэ хүрээнд банкуудын зээлийн нэгдсэн сан, скоринг үйлчилгээ, бичил зээлүүдийг харилцаа холбооны салбарын операторуудаар үзүүлэх, сошиал пэй үйлчилгээ, LendMN аппликэйшн зэрэг банк, технологийн компаниудын synergy, хамтын ажиллагаа аль хэдийн хэрэглээ болоод байна. Энэхүү дэвшилтэт хамтын ажиллагаа цаашид улам их өрнөх болно.

ЖДБ-ийн зээлийн санхүүжилтийн бодлого нь банк бүрийн хувьд цаашид ч хэвээр байх бөгөөд банкууд харилцагчдаа илүү ойртсон, өртгийн сүлжээг харгалзсан, тэднийг хөгжүүлснээр өөрсдөө ч ашгаа нэмэгдүүлэх боломжтой гэдгээ ухамсарласан, 2014 оноос хэрэгжиж буй Ногоон тогтвортой санхүүжилт хэмээх санаачлагаа улам бүр амьдралд нэвтрүүлэн, зээлийн бодлогодоо шингээсэн хандлагууд ойрын ирээдүйд банкны салбарт давамгайлах болно. Түүнчлэн, банкны тухай хууль шинэчлэгдэн, 2020 оноос банкны дүрмийн сангийн хэмжээ одоогийн мөрдөгдөж буй 50 тэрбум төгрөгөөс нэмэгдэх бол банкуудын дотор жижиг банкууд нэгдэх, эсвэл шинэ банк байгуулагдах, дампуурах үйл явцууд өрнөхийн зэрэгцээ банкны хуулийн шинэчилсэн найруулгын дагуу банкуудын засаглал, дотоод хяналт сайжрах болно. Ингэснээр банкны систем улам эрүүлжиж, олон улсын стандартад ойртох алхмууд шат дараатай хэрэгжинэ. ЖДБ-үүдийн хувьд барьцаа хөрөнгийн үнэлгээ нь хөндлөнгийн үнэлгээний компаниар олон улсын стандартын дагуу хийгдэж, банкууд татварын тайланг л үндэслэн зээл олгодог болсон тохиолдолд зээл авах шаардлага одоогийнхоос илүү чангарах магадлалтай. Энэ үйл явцад бэлтгэж ЖДБ-үүд өөрсдийн үйл ажиллагааг ил тод, үнэн зөв болгох, өөрсдийн бизнес, санхүүгийн мэдлэг, ур чадварыг сайжруулах шаардлага урган гарч байна.

4.3 ЖДБ-үүдэд шийдвэрлэх асуудал

Өөрчлөгдөн хувьсаж буй эдийн засаг, технологийн дэвшил болон санхүүгийн тогтолцоонд ЖДБ-үүд ч мөн адил хурдтай өөрчлөгдөж, дасан зохицох шаардлагатай байна. Манай улсын ЖДБ-үүд хэт жижиг, тархай бутархай, боловсруулах бус үйлчилгээний салбар ноёлж байгаа нь хөгжилд тодорхой хэмжээгээр саад тушаа болж байна. Энэ ч үүднээс бизнесүүдийн нэгдэл, хамтын ажиллагаа, өртгийн сүлжээний кластерийн бүтцүүд эрчимтэй бүрэлдэж, цогц байдлаар санхүүжилтээ шийдвэрлэдэг болох нь ирээдүйн хөгжилд хэрэгтэй билээ. ЖДБ-үүдийн тархай байдал нь хүний нөөц, хөрөнгө мөнгө, түүхий эд, техник технологи зэргийг ч тархаан

байршуулж, ингэснээрээ цөөн хүн амтай, жижиг зах зээлтэй манай улсын өрсөлдөх давуу байдалд сөргөөр нөлөөлж байгаа юм. Харин боловсруулах чиглэлийн кластеруудыг бий болгож, бүсүүдийн харьцангуй давуу талд суурилсан боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал болон дагалдах үйлчилгээг бодлоготойгоор хөгжүүлэх нь хувийн хэвшлийн болон нийт эдийн засгийн хөгжилд ихээхэн тустай байх биз ээ.

ЖДБ-үүдийн хувьд улам бүр чангарах банкны шаардлагыг хангахын тулд юуны өмнө санхүүгийн нэг тайлантай болж, бизнесийн санхүүгийн үйл ажиллагаагаа цэвэр, тунгалаг болгох хэрэгтэй байна. Энэ нь зөвхөн банкны шаардлагыг хангах бус цаашлаад үйл ажиллагаа нь томорч илүү их хэмжээний санхүүжилтийг хөрөнгийн зах зээл дээрээс бонд, хувьцаа гаргах замаар татахад нь үндсэн бэлтгэл ажил болох юм. Түүнчлэн, банкны зээлийг авахад шаарддаг бизнес төлөвлөгөө, мөнгөн урсгалын тооцоо, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө зэргийг өөрсдийн төсөлдөө нийцүүлэн үнэн бодитойгоор хийж сурах шаардлагатай.

Иймд бизнесийн байгууллагын удирдах ажилтнууд бизнес, санхүүгийн боловсрол, практик ур чадвараа ихээхэн хурдацтай сайжруулахгүй бол ирээдүйд улам л хүнд байдалд орно. Энэхүү шаардлагыг ЖДБ-үүд өөрсдөө ч нэлээд мэдрэх болсон.

4.4 Бусад байгууллагын оролцоо

ЖДБ-ийн санхүүжилтийн асуудлыг сайжруулахад зөвхөн банк гэлтгүй бусад оролцогч байгууллагууд болох зээлийн батлан даалтын сан, банкуудын холбоо болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үүрэг роль улам бүр нэмэгдэнэ.

Зээлийн батлан даалтын сан:

Ирэх жилүүдэд үйл ажиллагаа болох хамтын санхүүжилтийн нэг бүтээгдэхүүн нь Азийн хөгжлийн банкнаас Зээлийн батлан даалтын санд хэрэгжүүлж буй төсөл юм. Энэ төсөл хэрэгжсэнээр батлан даалт хийсэн хэмжээгээр тухайн банкинд батлан даалтын сангийн хадгаламж байршиж банкинд ч эрсдлийг нь бууруулна, итгэл үнэмшил төрүүлэх юм. Мэдээж 60 сая ам.доллартай тэнцэх батлан даалтын дүн байгаа тул өмнөх жилүүдээс олон тооны ЖДБ-үүд хүрэлцэхгүй байгаа барьцаа хөрөнгөндөө батлан даалт авах боломж бүрдэнэ. Ингэснээр илүү олон ЖДБ-ийн зээл олгогдоно хэмээн шинжээчид үзэж байна.

Банкуудын холбоо:

Банкуудын ашиг сонирхол, хамтын ажиллагааг зангиддаг гол байгууллага болох Монголын банкуудын холбооны зүгээс ч гэсэн ЖДБ-ийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр анхаарал хандуулж эхэлсэн. Энэ үүднээс 2017 оны 11 сард “ЖДБ-ийн санхүүгийн хүртээмж” сэдэвт форумыг зохион байгуулж, төрийн холбогдох байгууллага, банкуудтай хамтран энэ чиглэлд тодорхой бодлого, зохицуулалт, хамтын уялдаа холбоог сайжруулах зөвлөлийг байгуулан, цаашид тодорхой ахиц дэвшил гаргаж ажиллахаа амласан. Мөн зээлийн мэдээллийн сан, зээлийн скорингийн үйлчилгээг банкууд дан дангаараа явуулах нь зардалтай, үр ашиггүй, нэгдмэл байдлыг алдагдуулах тул энэ чиглэлүүд дээр тус холбоо нь голлох үүрэгтэйгээр оролцох бодолтой байгаагаа илэрхийлсэн.

Зөвлөх үйлчилгээний байгууллагууд:


Зөвлөх үйлчилгээний хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд энэ төрлийн компаниуд нь ЖДБ болон банк санхүүгийн байгууллагын хооронд гүүр болох болно. Учир нь ЖДБ болон банкууд бие биенээ шүүмжилдэг ч нягт хамтран ажиллаж байж бизнесүүд хөгжинө гэдгийг аль аль нь мэддэг болсон. ОУВС-ийн шаардлага болон банкны хуулийн өөрчлөлт нь ЖДБ-үүдийг банкнаас зээл авахын тулд улам бүр чадавхижихийг шаардах болно.

Шигтгээ 17:

Урт дунд хугацааны зүйлийг харж байгаа. Том харилцагч нартаа бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Гэхдээ энэ нь хүн хүч их шаарддаг юм байна, олон багш нар, олон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компаниуд шаардлагатай болж байна. Үүнийг EBRD ч юм уу бусад төсөл хэрэгжүүлдэг компаниудтай хамтраад хэрэгжүүлмээр байна. Энэ нь нийгмийн хариуцлага талаасаа авч явах зүйл.

Голомт банк

Банкуудаас зээл авахад шаарддаг бизнес төлөвлөгөө боловсруулах, мөнгөн урсгалын тооцоо хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, үйлдвэрлэл, хүний нөөцийн бодлогыг сайжруулах зэрэг олон зүйлсийг ЖДБ-үүд хийж чаддаггүй. Иймд банкны шаардлага болон ЖДБ-ийн бодит чадавхийн дунд томоохон зааг байгааг зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани, ТББ-ууд нөхөж, банк болон ЖДБ-ийг ойртуулахад гол хувь нэмэр үзүүлэх боломжтой.



Банкууд ч энэ байдлыг мэдрээд цаашид зөвлөх үйлчилгээ сайн үзүүлдэг компаниудтай хамтран ажиллах сонирхол байгаагаа хэлж байсан. Энэ хүрээнд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн REACH төслийн үйл ажиллагаа нь анхдагч болж, бусаддаа үлгэр дууриал болж байна. Цаашид зөвлөх үйлчилгээний компаниуд болон банкуудын хамтын ажиллагаа улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Түүнчлэн, зөвлөх компаниудын зүгээс тодорхой салбаруудын нарийвчилсан судалгааг төрийн байгууллага, банкуудын холбооны захиалгаар, эсвэл гадны байгууллагын санхүүжилтээр хийж санхүүгийн байгууллагуудад нээлттэй хэлбэрээр байршуулах хэрэгцээ шаардлага байгааг банкууд илэрхийлж байсан. Эдийн засгийн салбаруудын хөгжил, цаашдын хандлагын талаарх судалгаанууд хийгдэж, нэгдсэн мэдээллийн санд байршвал банкууд түүнийг ашиглан аль салбар, компанид олгохоо шийдвэрлэхэд дөхөм болно.

Шигтгээ 18:

Төрийн бүтэц нь хороо, хорооноос дүүрэг гээд явчихдаг. Хороо бүр бүр бизнес эрхэлдэг, ямар хүмүүс байгаагаа мэдээлж, дүүрэг дээр нэгтгэн мэдээллийн сантай болчихвол хэрэгтэй байх. Жишээлбэл, гоймонгийн бизнес хийдэг ийм хүмүүс байдаг г.м. Ингээд улсын хэмжээний мэдээлэлтэй болчихвол үүнийг банкууд харж байгаад тэдэн хувь нь гутлан дээр, тэдэн хувь нь эсгий эдлэл дээр гэдэг бодлогоо бариад хүмүүстээ хүрээд явчихвал аль аль талдаа амар юм болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол банкууд тухайн бизнес эрхлэгч нь ийм төрлийн бизнесийн хэдэн хувийг эзэлдэг гэх мэт судалгаа байхгүй харанхуйгаар яваад байна.

Үндэсний хөрөнгө оруулалтын банк

Энэ бүгдээс харахад талуудын нягт уялдаа холбоо бүхий хамтын ажиллагаа нь ЖДБ-ийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ чиглэлийн тодорхой санаачлагууд аль хэдийнэ хэрэгжиж эхлээд байна, цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Дүгнэлт

Аливаа улс оронд ажил эрхлэлтийн дийлэнхийг бүрдүүлдэг ЖДБ-ийн асуудлыг төрөөс чухалчлан авч үздэг. ЖДБ-ийн хөгжил нь эдийн засгийн тулгуур болсон хувийн хэвшлийн хөгжил, орлогын хуваарилалт, улсын бүтээмж болон өрсөлдөх чадварт ихээхэн нөлөөлдөг билээ. Энэ ч үүднээс манай улсын УИХ-аас ЖДҮ-ийн хууль, татварын тодорхой хөнгөлөлтүүдийг баталж, Засгийн газраас ЖДҮ-ийн сан, Сум хөгжлийн сангууд байгуулан, тэдгээрээр дамжуулан жижиг бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх, ноос ноолуур, сүү, барилга зэрэг тодорхой салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг олон арга хэмжээ явуулж байна. Гэхдээ эдгээрийн үр нөлөө нь хэр сайн байгаа ЖДБ-үүд болон санхүүгийн байгууллагууд шүүмжлэлттэй ханддаг. Засгийн газраас олон ажлыг явуулсан ч ЖДБ-үүдэд санхүүжилт ихээхэн хэрэгцээтэй хэвээр л байна.

Монгол банкнаас явуулдаг ЖДБ-ийн хөгжил, санхүүжилтийн талаарх 4 удаагийн судалгаагаар ЖДБ-ийн санхүүжилт нь хамгийн их тулгамдсан асуудлуудын нэг бөгөөд санхүүжилтийн хэрэгцээг хангахад банкууд голлон тусалдаг хэмээн ЖДБ-үүд хариулдаг. Санхүүгийн тогтолцооны 96 хувийг банкны салбар дангаараа бүрдүүлдэг, хөрөнгийн зах зээл нь сул хөгжсөн манай улсын хувьд арилжааны банкууд ЖДБ-ийн санхүүжилтийг голлон олгодог энэхүү байдал нь ирэх жилүүдэд ч өөрчлөгдөхгүй байх төлөвтэй.

Иймд уг судалгаагаар банкаар олгож буй ЖДБ-ийн санхүүжилтийн өнөөгийн байдал, цаашдын хандлагыг нийлүүлэгч тал болох банкуудын зүгээс судалгааны тодорхой аргуудыг ашиглан судалсан. Энэ хүрээнд банкны үйл ажиллагаа, зээл, эрсдлийн бодлогын захирлууд болон ЖДБ-үүдтэй тулж ажилладаг зээлийн мэргэжилтнүүдийг хамруулсан.

Эдийн засаг хүндрэлтэй байсан ч сүүлийн 6 жилийн дотор банкнаас хувийн хэвшилд олгосон зээлийн хэмжээ 3 дахин нэмэгдэж, зээл доторх дунд болон урт хугацаат зээлийн эзлэх хувийн жин харьцангуй нэмэгдсэн сайн талууд ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч нийт зээлд эзлэх ЖДБ-ийн зээл 18 хувь хэвээрээ байгаа нь энэ салбарт олгож буй зээл төдийлөн сайн нэмэгдэхгүй байгааг илтгэнэ.

Хэдийгээр судалгаанд оролцсон 12 банкны удирдлага нь банк бүр ЖДБ-д зээл олгох бодлого барьж байгаа учир нь ЖДБ-үүдэд зээл олгох нь банкны хувьд эрсдлээ тархаан байршуулах үндсэн стратеги болсон гэж байгаа боловч олгосон зээлийн хувь хэмжээ нэмэгдэхгүй байгаа нь зээлийн нөхцөл, зээлийн процесс болон ЖДБ-ийн харилцагчдын чадавхи сул байгаатай ихээхэн холбоотой юм.

Нэг талаас зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаа нь ЖДБ-үүдэд хүндрэл учруулдаг. Гэхдээ татан төвлөрүүлсэн хөрөнгийн дийлэнхийг бүрдүүлдэг 14-16 хувийн хүүтэй, 1 жил хүртэлх хугацаатай хадгаламжинд

өөрчлөлт гарахгүй тохиолдолд үүнд суурилан олгогддог зээлийн хүү болон хугацаа нь ирэх жилүүдэд ч төдийлөн өөрчлөгдөхгүй болов уу. Харин Голомт банкнаас санаачлан Монгол банкнаас дэмжин бодлого хэрэгжүүлэхээр судалж буй “Зээлийн хүүг бууруулах үндэсний хөтөлбөр” ирэх жилүүдэд хэрэгжвэл зээлийн хүү бодитойгоор буурах боломж бүрдэнэ.

Нөгөө талаас банкны зээл авахад шаарддаг барьцаа хөрөнгө нь ЖДБ-үүдийн шүүмжилдэг дараагийн нэг асуудал юм. Судалгааны явцад ЖДБ-үүдийн барьцаа хөрөнгийг банкууд доогуур үнэлдэг гэдэгтэй зээлийн мэргэжилтнүүд санал нийлж байгаа ч банк эрсдэлээ бодоод ийм алхам хийдэг хэмээн хариулсан. Хөдлөх хөрөнгийг барьцаалах хууль 2017 оны 03 сараас хэрэгжиж эхэлсэн ба энэ чиглэлд дорвитой ахиц гарвал цаашид ЖДБ-ийнхэн хөдлөх хөрөнгөө барьцаалан зээл авах боломжтой. Харин ОУВС-ийн шаардлагаар банкны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний компаниуд хийх тохиолдолд барьцаа хөрөнгийг олон улсын стандартын дагуу үнэлэх тул ЖДБ-үүдийн барьцаа хөрөнгийг илүү доогуур ч үнэлж болзошгүй хэмээн банкны удирдлагууд хэлж байв.

Зээлийн процессийн хүрээнд зээлийн хүсэлтийг авснаас хойш зээлийн мэргэжилтэн дунджаар 63 цаг буюу 8 ажлын өдөрт судалж, зээлийн хороонд шилжүүлдэг. Зээлийн мэргэжилтнүүдийн хувьд ЖДБ-үүдийн мөнгөн урсгалын тооцоо, бизнес төлөвлөлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө дээр хамгийн их цаг зарцуулдаг бөгөөд ЖДБ-үүд эдгээрийг хийж чаддаггүй байна. Иймд ЖДБ-үүд үнэн зөв санхүүгийн нэг тайлантай болж, санхүү, бизнесийн мэдлэг, ур чадвартай болбол банкуудад ирэх зээлийн хүсэлтийн чанар сайжирч, зээл судлах хугацаа ч богиносно хэмээн банкны ажилтнууд хариулсан. Энэ чиглэлд зөвлөх үйлчилгээний байгууллагууд анхаарал хандуулж, ЖДБ-үүдэд санхүү, бизнесийн боловсрол олгож, тодорхой ур чадварыг сайтар эзэмшүүлэх шаардлагатай байна.

ЖДБ-ийн санхүүжилтийг сайжруулах нь дан ганц банкны асуудал биш бөгөөд санхүүжилтийг хүртэгч ЖДБ-үүд чадавхижих, санхүүгийн сахилга баттай болох, тэдгээрийг чадавхижуулах зөвлөх үйлчилгээний компаниудын үйл ажиллагаа сайжирч, бодлого, хууль эрхзүйн зохицуулалтыг боловсруулж, ЖДБ-ийг цогцоор нь дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх төр байгууллагуудын уялдаа холбоо, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа шинэ шатанд гарах шаардлагатай байна.

Ашигласан материал:

Монголбанк. (2010, 2016). Банкуудын зээлийн тайлан, УБ хот

Монголбанк. (2016). Банкуудын нэгдсэн тайлан, УБ хот

Монголбанк. (2011, 2012, 2014, 2017). Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал, УБ хот

УИХ. (2007). Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль

ҮСХ. (2017). Статистикийн эмхтгэл 2016. УБ хот

World Bank. (2014). Doing business 2015: Going beyond efficiency

Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн мэдээлэл

Зээлийн батлан даалтын сангийн мэдээлэл

Сум хөгжлийн сангийн мэдээлэл

ЖАЙКА-ийн Хоёр үе шатат зээл төслийн мэдээлэл

АХБ-ны Хөдөөгийн хөгжил төслийн мэдээлэл

Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн мэдээлэл

KfW төслийн мэдээлэл



Хавсралт

Хавсралт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

А. Судалгаанд оролцогчид

№	Банкны нэр	Удирдах албан тушаалтан (Чанар)	Харилцагчийн менежер (Тоо)
1	Хаан банк	1	5
2	ХХБ	1	4
3	Голомт банк	1	4
4	Хас банк	1	4
5	Төрийн банк	1	4
6	Капитрон банк	1	3
7	Капитал банк	1	2
8	Ариг банк	1	2
9	УБ хотын банк	1	2
10	Богд банк	1	1
11	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	1	1
12	Чингис хаан банк	1	1
Нийт		12	33

Б. Судалгаанд хамрагсдын хувь, ажлын байраар В. Хийж гүйцэтгэдэг ажилд эзэлж буй ЖДБ-үүдэд зээл олгох ажлын хувь



Г. Судалгаанд хамрагдагсдын ажилласан хугацаа, тоо хувиар, ажилладаг нэгжээр

Ажилласан хугацаа	Ажилладаг нэгж				Нийт дүн	
	ЖДБ-ийн төв	Зээлийн төв	Салбар	Тооцооны төв		
	Тоо	Тоо	Тоо	Тоо	Тоо	Хувь
1 хүртэлх жил	1	0	0	1	2	6.1
1-3 жил	0	4	3	4	11	33.3
3-5 жил	0	5	2	0	7	21.2
5-аас дээш жил	1	4	5	3	13	39.4
Нийт дүн	2	13	10	8	33	100

Хавсралт 2. Судалгааны асуулгын маягт

"Банкаар олгогдож буй жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн өнөөгийн байдал, цаашдын хандлага" сэдэвт судалгаа
Арилжааны банкуудын харилцагчийн менежерүүдээс авах асуулга
Энэхүү асуулгыг "Банкаар олгогдож буй жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн өнөөгийн байдал, цаашдын хандлага" хэмээх судалгааны ажлын хүрээнд арилжааны банкуудын зээлийн эдийн засагч нараас түүвэрлэн авч оролцуулж байна. Асуулгын зорилго нь банкуудын ЖДБ-ийн зээлийн бодлогын хэрэгжилт, сайжруулах боломжийг тодорхойлох, ЖДБ эрхлэгчдийн хувьд банкны шаардлагыг хангахад ямар хүндрэл бэрхшээл учирдаг, тэдгээрийг даван туулах ямар арга замууд байж болох талаар харилцагчидтай шууд ажилладаг банкны ажилтнуудын санаа бодлыг мэдэж, судалгааны тайландаа тусган холбогдох зөвлөмжийг боловсруулахад оршино.
<i>Та дараах сонголттой асуултуудаас холбогдох хариултыг дугуйлна уу. Зарим асуултын хувьд өгөгдсөн зайд өөрийн хариултыг бичнэ үү.</i>
А. Үндсэн мэдээлэл:
1) Та аль банкинд ажилладаг вэ?
2) Таны дараах нэгжийн алинд ажилладаг вэ? а. ЖДБ-ийн төв б. Зээлийн төв в. Салбар г. Тооцооны төв
3) Та харилцагчийн менежерийн албан тушаалд хэдэн жил ажиллаж байна вэ? а. 1 хүртэлх жил б. 1 - 3 жил в. 3 - 5 жил г. 5-аас дээш жил
4) Танай салбарт ирсэн нийт зээлийн хүсэлтийн хэд орчим хувь нь ЖДБ-ийн зээлтэй холбоотой байдаг вэ? а. 20% хүртэл б. 20-40% в. 40-60% г. 60%-аас дээш
5) Эдгээр ЖДБ-ийн зээлийн хүсэлтийн хэд орчим хувь нь бодитойгоор зээл болон олгогддог вэ?
6) Таны хийж гүйцэтгэдэг ажлын хэд орчим хувийг ЖДБ-үүдэд зээл олгохтой холбоотой ажил эзэлдэг вэ? а. 20% хүртэл б. 20-50% в. 50-70% г. 70%-аас дээш

- 17) Таны зүгээс зээл хүсэж ирсэн харилцагчтай зээл олгох хүртэлх хугацаанд ойролцоогоор хэдэн удаа уулздаг вэ?
а. 3 хүртэлх удаа б. 3-5 удаа в. 5-7 удаа г. 7-оос дээш удаа
- 18) Зээл авахад шаардлагатай бичиг баримтуудыг банкинд бүрдүүлж өгөхөд нэг харилцагч ойролцоогоор хэдэн өдөр, эсвэл сар зарцуулдаг вэ?
..... өдөр Эсвэл сар
- 19) Таны зүгээс харилцагчаас ирүүлсэн зээлийн хүсэлт болон холбогдох баримтуудын бүрэн бүтэн байдлыг шалгахад хэдэн минут, эсвэл цаг зарцуулдаг вэ?
..... минут эсвэл цаг
- 20) Ирүүлсэн ЖДБ-ийн зээлийн хүсэлтийн хэд орчим хувь нь бичиг баримтын бүрдүүлэлт дутуу байдаг вэ?
а. 20% хүртэл б. 20-40% в. 40-70% г. 70%-аас дээш
- 21) Дутуу бүрдэлтэй байгаа тохиолдолд та ямар арга хэмжээ авдаг вэ?
а. Утасдана б. Уулзана в. Бүрдүүлэхэд тусална г. Мэдэхгүй
- 22) Дутуу бүрдсэн зээлийн хүсэлтийн хойноос та ойролцоогоор хэдэн удаа утасдаж, эсвэл уулзаж байж бичиг баримтыг бүрэн бүрдүүлдэг вэ?
а. 3 хүртэлх удаа б. 3-5 удаа в. 5-7 удаа г. 7-оос дээш удаа
- 23) Бизнес эрхлэгчид таны хэлсний дагуу бичиг баримт бүрдүүлэхдээ юун дээр хамгийн их уддаг вэ?
.....
- 24) Бичиг баримт бүрдүүлэхэд уддаг шалтгаан нь ихэвчлэн ямар хүчин зүйлстэй холбоотой байдаг вэ? Гол гэж үзсэн 2 хариултыг дугуйлна уу.
а. Ямар баримтууд өгөхөө мэддэггүй б. Эзэмших эрхийн гэрчилгээ байхгүй, алдаатай
в. Барьцаа хөрөнгийн үнэлгээ г. Бизнес төлөвлөгөө боловсруулах
д. Төслийн ирээдүйн орлогоо тооцоолох е. Санхүүгийн тайлангаа гаргаж өгөх
ё. Улсын бүртгэлтэй холбоотой ж. Бусад
- 25) Та нэг ЖДБ-ийн зээлийн хүсэлтийн дагуу холбогдох шинжилгээ, судалгааг хийхэд ойролцоогоор хэдэн цаг, эсвэл өдөр зарцуулдаг вэ?
..... цаг эсвэл өдөр
- 26) Зээлийн хүсэлтийг судлах явцад та юун дээр хамгийн их цаг зарцуулдаг вэ?

- а. Бичиг баримтын бүрдүүлэлт
в. Мөнгөн урсгалын тооцоо
- б. Бизнес төлөвлөгөөний боловсруулалт
г. Зээлийн тооцоолол
- 27) Зээлийн хүсэлтийг судлахад хамгийн их хүндрэл учруулдаг зүйлс нь юу байдаг вэ?
- а. ЖДБ-ийн бизнес төлөвлөгөө сайн боловсруулаагүй
б. Мөнгөн урсгал, хөрөнгө оруулалтын тооцоолол хийгдээгүй
в. Санхүүгийн тайлангууд нь үнэн зөв биш
г. Бичиг баримтын бүрдүүлэлт дутуу
- 28) Харилцагчдын хувьд хэрэгцээгүй олон бичиг баримт шаардлаа хэмээн гомдоллодог уу?
- а. Тийм
б. Үгүй
в. Мэдэхгүй
- 29) Танай банкнаас зээл хүсэхтэй холбогдон тавигддаг аль шалгуурыг ЖДБ болон бизнес эрхлэгчид хангаж чаддаггүй вэ?
-
- 30) Таны зүгээс ЖДБ-ийн харилцагчдаа бизнес төлөвлөгөө, мөнгөн урсгал зэргээ боловсруулахад нь аргазүйн зөвлөгөө өгөх, хийхэд нь туслах тохиолдол бий юу?
- а. Тийм
б. Үгүй
- 31) Хэрэв тусалж байсан бол нэг сард ойролцоогоор хэдэн харилцагчид ийм төрлийн тусалцаа өгдөг вэ?
- харилцагч
- 32) Энэ тохиолдолд нэг харилцагчид хэд орчим цаг зарцуулдаг вэ?
- цаг
- 33) Харилцагчдын хамгийн их ойлгож, эсвэл хийж чадахгүй байдаг хэсгүүд нь аль нь вэ? Гол гэж үзсэн 2 хариултыг сонгоно уу.
- а. Бизнес төлөвлөгөө бичих
б. Мөнгөн урсгалыг тооцох
в. Төслийн үр ашгийг үнэлэх
г. Зээлийн хүсэлтийг бөглөх
д. Төслийн санааг сайн бичих
е. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
ё. Барьцаа хөрөнгийн үнэлгээ
ж. Бусад
- 34) Таны бодлоор зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд дараах зүйлсийн алийг нь харилцагчдад зөвлөж тусалбал та бүхэний ажлыг хамгийн их хөнгөвчлөнө гэж бодож байна вэ? (2-ыг сонгоно уу)

- | | |
|---|----------------------------------|
| а. Бизнес төлөвлөгөө бичих | б. Мөнгөн урсгалыг тооцох |
| в. Төслийн үр ашгийг үнэлэх | г. Зээлийн хүсэлтийг бөглөх |
| д. Төслийн санааг сайн бичих | е. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө |
| ё. Санхүүгийн тайлангаа үнэн зөв гаргах | ж. Бусад |

35) ЖДБ-үүд цаашид хэрхэн өөрчлөгдвөл та бүхэний ажилд илүү дөхөм болох вэ?
(Хамгийн гол гэсэн 2 хариултыг дугуйлна уу)

- | | |
|---|--|
| а. Санхүүгийн нэг л тайлантай болох | б. Сайн боловсруулсан бизнес төлөвлөгөөтэй |
| в. Бүрдүүлэх баримтыг бүрэн бүрдүүлдэг | г. Зээлийн хүсэлтээ зөв бөглөдөг |
| д. Мөнгөн урсгал, төслийн тооцоог хийж чаддаг | е. Бичиг баримтын зөрчилгүй байх |
| ё. Зээлийн мэдээллийн нэгдсэн сайн сантай болох | ж. Үнэнч хандлага |
| з. Зээлээ хугацаанд нь төлдөг болох | и. Бусад |

36) Таны бодлоор барьцаанд тавих үндсэн хөрөнгийн үнэлгээг банкууд хэт доогуур үнэлдэг гэж шүүмжилдэгийг дэмжих үү?

- | | | |
|---------|---------|-------------|
| а. Тийм | б. Үгүй | в. Мэдэхгүй |
|---------|---------|-------------|

37) Дэмжихгүй бол шалтгаанаа тайлбарлана уу.

.....
.....

38) Хууль эрхзүй, дүрэм журам, эсвэл банкны дотоод журам зэргээс таны ажилд хүндрэл учруулдаг заалт бий юу? Байдаг бол тэдгээрийг хэрхэн өөрчилвөл зүйтэй хэмээн та бодож байна вэ?

.....
.....

Судалгаанд идэвхитэй оролцож, санал бодлоо харамгүй хуваалцсан танд баярлалаа.

**Хавсралт 3. Банкны удирдлагуудаас авсан ганцаарчилсан
ярилцлагын чиглүүлэх асуултууд**

ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТУУД

Банкны нэр:
Ярилцагчийн нэр, албан тушаал:
Уулзсан өдөр, цаг:

АСУУЛТУУД:

1. ЖДБ-ийн хөгжлийн өнөөгийн байдлыг хэрхэн дүгнэдэг вэ?
2. ЖДБ-ийн зээлийн талаар танай банк ямар бодлого баримталдаг вэ? Урьд нь ямар бодлоготой байсан, сүүлийн үед хэрхэн өөрчлөгдсөн бэ?
3. ЖДБ гэдгийг танай банк хэрхэн тодорхойлдог вэ?
4. Танай банканд жижиг, дунд зээл хариуцсан тусдаа салбар, хэлтэс байдаг уу?
5. Танайх ямар зээлийн бүтээгдэхүүнүүдийг харилцагч ЖДБ-дэд санал болгодог вэ? Банкны өөрийн бизнесийн зээл, төслийн зээлүүд г.м.
6. Жижиг, дунд зээлийн эрэлт хэр их байдаг вэ? Танайд ирсэн жижиг, дунд зээл авах хүсэлтийн ойролцоогоор хэдэн хувьд нь бодитойгоор зээл болон олгогддог вэ?
7. Бусад ЖДБ-ийн төслийг санхүүжүүлдэг, зээл олгодог санхүүгийн байгууллагууд, ЖДБ-ийн сан, гадны төсөл хөтөлбөртэй хэр их хамтарч ажилладаг вэ? Ямар хэлбэрээр хамтардаг вэ?
8. Жижиг, дунд зээл олгохтой холбогдон гардаг гол бэрхшээлүүд нь юу байдаг вэ? Тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх боломжтой гэж та үздэг вэ?
 - a. хууль эрх зүйн хувьд
 - b. зээлийн хэмжээ, барьцаа хөрөнгө, бизнес төлөвлөгөө г.м\
9. Жижиг зээл олголт нь банкны хувьд зардал, эрсдэл ихтэй үйл ажиллагаа учраас зээлийн нийт багцад бага хувийг эзлэх нь зүйтэй гэдэгтэй та санал нийлдэг үү?
10. ЖДБ-д банкны зүгээс урт хугацааны зээл олгох боломж байдаг уу? Тодорхой тайлбарлана уу. Хөгжүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?
11. Цаашид банкнаас баримтлах ЖДБ-ийн санхүүжилтийн бодлого хэрхэн өөрчлөгдөх хандлагатай байна вэ? Танай олгож буй ЖДБ-ийн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, нөхцөл, шаардлага хэрхэн өөрчлөгдөх байх гэж та бодож байна вэ?
12. ЖДБ-ийн санхүүжилтийг сайжруулахын тулд ямар арга хэмжээ, шийдлийг авч хэрэгжүүлбэл зүйтэй хэмээн та бодож байна вэ? (Ямар субъектууд, ямар арга хэмжээ авах шаардлагатай байна вэ?) Зээлдэгчийн мэдээллийн нэгдсэн сан, Зээлийн батлан даалтын сан г.м